



MONGOLIAN CASHMERE

GOBI CORPORATION

MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ

ЖИЛИЙН ТАЙЛАН 2015

АГУУЛГА

1.	ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ.....	4
2.	ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ.....	5
3.	САЛБАРЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ОРЧИН, ЭРСДЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛҮҮД.....	6
4.	НООЛУУРЫН САЛБАР.....	8
5.	ГОВЬ КОМПАНИ САЛБАРТАА.....	9
6.	МАНАЙ ХАРИЛЦАГЧИД.....	10
7.	БИДНИЙ АМЖИЛТ.....	11
8.	КОМПАНИЙН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ТӨЛӨВЛӨГӨӨ.....	12
9.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	15
10.	КОМПАНИД ШИНЭЭР НЭВТРҮҮЛЖ БУЙ АМЁБ МЕНЕЖМЕНТИЙН ТАНИЛЦУУЛГА.....	18
11.	ГАДААДЫН ДАХЬ ГОВЬ НЭРИЙН ДЭЛГҮҮРҮҮД.....	20
12.	ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН.....	21
13.	ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦАА.....	31
14.	НОГДОЛ АШИГ.....	33
15.	КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ.....	34
16.	ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ХОЛБОГДОХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА, АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	41
17.	ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ.....	84
	МЭНДЧИЛГЭЭ.....	84
	ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ.....	85
	ХУРАЛД ОРОЛЦОХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ, УГ БИЧИГ БАРИМТТАЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ ГАЗАР, ХУГАЦАА.....	86
	ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД.....	88
	ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ.....	98
	САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР.....	102

Хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, бизнесийн түнш, хамтран ажиллагсад та бүхэндээ чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье.

“Дэлхийд танигдсан Монгол бренд” уриатай “Говь” ХК нь 1981 онд Монгол Улсын ууган үйлдвэрүүдийн нэг Говь комбинат нэртэйгээр анх үүсгэн байгуулагдсан цагаасаа Монгол улсынхаа эдийн засаг, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсаар ирлээ.

Энэ жил манай компани үүсгэн байгуулагдсныхаа 35 жилийн ойг тэмдэглэх гэж байгаа бөгөөд түүхэн энэ жилүүдэд тус байгууллагын үе үеийн удирдлага, хамт олны хүчин зүтгэл, хөдөлмөрийн үр дүнд манай байгууллага өргөжин тэлж, улсын хэмжээнд нэр хүндтэй томоохон компани болон тодорсныг энд цохон тэмдэглэхэд таатай байна.

Говь ХК нь 2007 онд анх хувьчлагдахад нийт хөрөнгийн хэмжээ 27 тэрбум байсан бол эдүгээ 122.8 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, жилд 70 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 1300 гаруй хүнийг ажлын байраар хангасан, улсын төсөвт жилд 10 гаруй тэрбум төгрөгийн татвар, хураамж төвлөрүүлсэн үндэсний хэмжээний томоохон компани болоод байна.

Хувьсан өөрчлөгдөж буй хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангах, эрчимтэй хөгжиж буй ноолуурын салбарт өөрийн байр суурийг хадгалахын тулд зөв боловсон хүчин, зөв технологиор хэрэглэгчдийн таашаалд нийцсэн загварлаг бүтээгдэхүүнийг чанарын өндөр түвшинд үйлдвэрлэн тохиромжтой цагт нь зохистой үнээр зах зээлд нэвтрүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Энэхүү шаардлагын улмаас бид сүүлийн жилүүдэд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөө шинэчилэх, технологио сайжруулах, боловсон хүчнээ сургаж дадлагажуулах ажлыг шат дараалан авч ирсэн бөгөөд 2015 онд бүтээгдэхүүний чанар, өнгө дизайныг сайжруулах зорилтын хүрээнд бүтцийн өөрчлөлт хийж, урьд нь хэлтэс, албаны статустай ажиллаж байсан чанар, загварын нэгжүүдийг Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн газар, Чанар стандарт баталгаажуулалтын газар болгон томосголоо.

Монгол улсын хосгүй үнэтэй баялаг болсон Монгол ноолуурыг дэлхийн зах зээлд бренд болгохын тулд бид бүтээгдэхүүнээ илүү загварлаг, илүү тансаг, илүү эко болгохыг зорьж судалгаа хөгжүүлэлтийн ажлыг хийсээр ирсний жишээ нь бидний бий болгосон Organic cashmere(будаг, химийн бодис хэрэглээгүй), Light Cashmere(зуны ноолуур), Golden Mix-(торго, хөвөнгийн хольцтой) брендүүд юм.

Бид 2015 онд хийсэн бүтээсэн амжилтаа үнэлүүлж МҮХАҮТ-аас “2015 ОНЫ ШИЛДЭГ ЭЦСИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОГЧ”, “ТОП-150”, ГОЁЛ-2016 наадмаас “ШИЛДЭГ ЗОХИОН БҮТЭЭХ ТОВЧОО”-ны цом өргөмжлөлүүдийг гардан авлаа.

Миний бие тус компанийн гүйцэтгэх захирлын хувиар Говь ХК-ийг зах зээлд тэргүүлэгчийн байр сууриа хадгалж, улсын орныхоо эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулах ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ, ХАРИЛЦАГЧ, АЖИЛЛАГСАДЫН САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ хөнгөн үйлдвэрлэлийн салбарын жишиг компани байлгахыг эрхэм зорилгоо болгон ажиллах болно.

Бидний ололт амжилтыг цаг үргэлж дэмжиж байдаг та бүхэндээ сайн сайхныг хүсч, цаашдын ажил үйлст тань өндрөөс өндөр амжилт хүсэн ерөөе.

Хүндэтгэсэн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.БААТАРСАЙХАН

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, хамтран ажиллагсад та бүхэндээ Төлөөлөн удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье.

Говь ХК-ийн ТУЗ нь үйл ажиллагаандаа компанийн сайн засаглалын зарчмыг баримталж, компанийн засаглалын хөгжилд манлайлан, бусад компаниудад үлгэр дуурайлал болохыг зорьж ирсэн бөгөөд энэ чиглэлээр төр засгийн байгууллага, мэргэжлийн зохицуулах байгууллага, ТББ-уудтай нягт хамтран ажиллаж, сургалт семинар, арга хэмжээнүүдэд тогтмол идэвхитэй хамрагдаж ирлээ. Үүний нэг тод жишээ нь 2014 оны 12 сарын 24-нд “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг идэвхжүүлэхээр Компанийн засаглалын үндэсний зөвлөл, Монголын хөрөнгийн биржийн санаачилгаар “САЙН ЗАСАГЛАЛТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛОХООР ХИЧЭЭЖ АЖИЛЛАХ ТУНХАГ БИЧИГ”-т нэгдсэн явдал юм.

Ийнхүү компанийн засаглалыг сайжруулахаар чармайж ажилласны үр дүнд Говь ХК нь 2015 онд хувьцаа нь хамгийн идэвхтэй арилжигдсан, зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр, ногдол ашиг тогтмол олгодог, мэдээллийн ил тод байдлыг ханган ажилладаг үзүүлэлтээр “ШИЛДЭГ ХУВЬЦААТ КОМПАНИ”-иар шалгарч өргөмжлөл авсан билээ.

2016 онд ч ТУЗ-ийн гол үйл ажиллагаа маань сайн засаглалыг хэрэгжүүлж өргөжүүлэхэд чиглэгдсэн хэвээр байх болно.

Эдийн засгийн орчин муу байгаа энэ үед компанийн өмнөө тавьсан зорилтыг хэрэгжүүлэхэд амаргүй байсан хэдий ч компанийнхаа үйл ажиллагааны онцлог, бизнесийн орчинг сайн мэддэг менежментийн өргөн хүрээний мэдлэг, туршлагатай, чадварлаг удирдлагууд, компанийнхаа нэр хүндийг эрхэмлэн, шаргуу ажилладаг ажилчин албан хаагчдын маань нөр их хөдөлмөрийн ачаар 2015 онд компанийн борлуулалтыг 7.5 хувиар өсгөж, ашгийг өнгөрсөн жилийн түвшинд барьж чадлаа.

Монгол Улсын Засгийн газраас санаачлан хэрэгжүүлсэн ноос ноолуурыг салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих удаа дараагийн арга хэмжээний үр дүнд ноолуурын салбарын технологийн шинэтгэлд дорвитой ахиц гарч, санхүүжилт нэмэгдснээр аж ахуйн нэгжүүд түүхий эдээ хангалттай хэмжээгээр бэлтгэх, улмаар ноолуурыг боловсруулан нэмүү өртөг шингээх замаар ДНБ-ий өсөлтөнд ч хувь нэмрээ оруулах боломжийг олгосон оновчтой арга хэмжээ байсныг дурьдахад таатай байна.

2015 онд компанид бүтцийн өөрчлөлт хийж, зорилтот зах зээл рүүгээ илүү чиглэсэн оновчтой менежментийн тогтолцоог бий болгон, чиглэл чиглэлээр мэргэшсэн хүмүүсээр удирдлагын багыг бүрдүүлсэн нь компанийн 2016 оны сртатегийн зорилтуудыг хангахад бодитой хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Энэ завшааныг ашиглан 2015 онд дэвшүүлсэн зорилго зорилтондоо хүрэхийн тулд хичээл зүтгэлтэй сайн ажилласан компанийн удирдлагууд болон нийт ажиллагсаддаа талархал дэвшүүлье.

Эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг үл харгалзан, үргэлж хамт байдаг бүх харилцагч, зээлдүүлэгч болон бизнесийн түншүүддээ баярлалаа. Бидний санал болгосон бүтээгдэхүүнийг сонгон хэрэглэсээр ирсэн үнэнч хэрэглэгчиддээ баярлалаа.

Та бүхэнд талархал илэрхийлж, ажлын амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн өрөөе!

Хүндэтгэсэн
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ХҮРЭЛБААТАР

НООЛУУРЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Ноос ноолуурын салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээ, ажиллагсадын тоо зэргээрээ нийгэм, эдийн засагт жинтэй хувь нэмэр оруулж байгаа уул уурхайн салбарын дараа орох стратегийн өндөр ач холбогдолтой салбар тул Засгийн газраас тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт тооцон дэмжих бодлогыг явуулж, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ноолуурын салбарын зээлийн санг дахин нэмэгдүүлж 300 тэрбум төгрөгт хүргэх, малын гаралтай түүхий эд, ноолуур, ноос, арьс ширийг боловсруулж, зах зээлд нийлүүлдэг болох зорилтыг тавин шат дараалсан арга хэмжээ авч байгаа билээ.

Энэхүү бодлогын хүрээнд 2011 оноос хойш дараах эрх зүйн баримт бичгүүдийг батлан, хэрэгжүүлж байна. Үүнд:

- “Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх” УИХ-ын 2011 оны 30 дугаар тогтоол
- Засгийн газрын 2011 оны 221, 368 дугаар тогтоол – “Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, ноос боловсруулах үндэсний үйлдвэрлэгчийг Засгийн газрын бондын эх үүсвэрээр дэмжих хөрөнгийг зарцуулах, хяналт тавих, тайлагнах тухай журам”
- Засгийн газрын 2013 оны “Ноолуурын салбарт техник технологийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх тухай” 126- дугаар тогтоол
- Засгийн газрын 2013 оны “Үйлдвэрлэлийг дэмжих тухай” 141-р тогтоол
- Засгийн газрын 2014 оны “Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 87-р тогтоол
- Засгийн газрын 2015 оны “Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 149-р тогтоол
- Засгийн газрын 2015 оны “Ноолуурын салбарын эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх тухай” 171-р тогтоол

Эдгээр арга хэмжээний үр дүнд 2011-2015 онуудад ноолуур боловсруулах 42 үйлдвэр Засгийн газрын хөнгөлөлттэй зээлд хамрагдан, хэрэгцээт түүхий эдээ хангалттай хэмжээгээр бэлтгэж, тоног төхөөрөмжийн шинэтгэл, хүчин чадлын өргөтгөлийн ажлыг хийн, 2014 онд үндэсний үйлдвэрүүд нийтдээ 2600 тонн түүхий ноолуур бэлтгэсэн нь урьд жилээс 2 дахин өссөн үзүүлэлт байсан бөгөөд үйлдвэрлэлт, борлуулалт 35-40%-иар өссөн байна.


Гэвч бэлтгэж буй ноолуурын 75 орчим хувийг зөвхөн угаасан, самнасан хэлбэрээр буюу өртөг бага шингээж экспортолсон байгаа бөгөөд ноолууран түүхий эдээ дотооддоо 100 хувь боловсруулбал 2 их наяд төгрөгийн үйлдвэрлэл хийх боломж бүрдэх юм.

Иймээс Аж Үйлдвэрийн яамнаас Ноос, ноолуурын салбарын 2016-2018 оны хөгжлийн зорилт-ыг “Улсын хэмжээнд жил бүр бэлтгэж буй ноос, ноолуурыг 100 хувь дотооддоо боловсруулах” хэмээн тодорхойлж, үүний тулд:


- 2016 оноос угаасан ноос, ноолуурын экспортыг зогсоох, 50 хувийг хагас боловсруулж самнасан хэлбэрээр экспортод, үлдсэн 50 хувиар нь бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх.
- Сүлжмэл бүтээгдэхүүнийг 3,6 сая ширхэг, нэхмэл бүтээгдэхүүнийг 440 мян.м-т хүргэх
- 2017 оноос самнасан ноолуурын экспортыг зогсоож, 100 хувь дотооддоо боловсруулж, эцсийн бэлэн бүтээгдэхүүн Сүлжмэл 6 сая ширхэгт, нэхмэл бүтээгдэхүүнийг 1,2 сая.м-т хүргэх
- дээрх зорилтуудыг хэрэгжүүлснээр салбарын нийт бүтээгдэхүүний борлуулалтыг ноолуурт 1.9 их наяд төгрөгт, ноосон бүтээгдэхүүний борлуулалтыг 244 тэрбум төгрөгт тус тус хүргэж, ажлын байрыг 30.0 мянга хүргэх зорилт тавин ажиллаж байна.

ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС

- Эдийн засгийн хүндрэлтэй байдал үргэлжилж, хэрэглэгчдийн худалдан авах чадвар муудаж байгаа
- Цаг уурын хүндрэлтэй нөхцөл нь малын тоо толгойг бууруулснаас түүхий эдийн нийлүүлэлт багасч, үнэ өсөх
- Засгийн газраас ноолуурын салбарыг дэмжих бодлого хэрэгжүүлж, өрсөлдөгч компаниудын тоо олширч, үйлдвэрлэлийн хүчин чадал сайжирч байгаа тул зах зээлд эзлэх байр сууриа хадгалах, улмаар тэлэхийн тулд ихээхэн чармайлт гаргах шаардлагатай болж байна.



Дэлхийн түүхий ноолуурын хэрэгцээний 40-45 хувийг Монгол улс бүрдүүлдэг бол 50 хувийг нь БНХАУ, үлдсэн 10 хувийг Иран, Афганистан улсууд нийлүүлж байна.




 Бохир ноолуур **4035** тонн
 Самнасан ноолуур **630** тонн
 Сүлжмэл бүтээгдэхүүн **300** мян.ш

ЭКСПОРТ
300,000,000,000.00₮

Ямааны тоо толгой
 2014 онд 19,2 сая
 2015 онд 22,0 сая




Манай улс 2015 онд

80000

орчим тн ноолуур бэлтгэжээ.

Гүн боловсруулалт хийсэн ноолуур



60%

анхан шатны боловсруулалт хийсэн ноолуур

130 


Ноолуур боловсруулах салбарт үйл ажиллагаа явуулж байгаа жижиг, дунд, том үйлдвэрүүд

Ноолуур гүн боловсруулах үйлдвэр


> **15**

САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ


Ноос, ноолууран утасны үйлдвэрлэлт
2014 онд Улсын хэмжээнд 2400 тонн
Говь ХК 438 тонн




Сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлт
2014 онд Улсын хэмжээнд 954,4 мян.ш
Говь ХК 488 мян.ш




Нэхмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлт
2014 онд Улсын хэмжээнд 326,8 мян.м
Говь ХК 170,2 мян.м



Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлт
2014 онд Улсын хэмжээнд 56,5 мян.ш
Говь ХК 28,3 мян.ш



ДОТООДЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



САЛБАРТАА АНХ УДАА



Принттэй бүтээгдэхүүн



Зуны ноолуур




Golden mix



Organic cashmere



Ноолууран брук



Ноолууран бүрх малгай

МАНАЙ ХАРИЛЦАГЧИД





Монгол улсын Засгийн газар
МҮХАУТанхим
2014 оны “ТОП-100” ААН-ийн
23-т шалгарсан



Аж үйлдвэрийн яам
“Аж үйлдвэрийн салбарын
тэргүүн дээд шагнал”
БЭЛЭГТ ГӨРӨӨС цом



Гоёл 2016 наадам
“Шилдэг зохион бүтээх
товчоо” шагнал



Хаан банк
“Хүндэт харилцагч-Эрхэм түнш”



Аж үйлдвэрийн яам, Монголын ноос ноолуурын холбоо,
Монголын арьс ширний холбоо хамтарсан “Арьс шир
ноос ноолууран бүтээгдэхүүн-2015” арга хэмжээнээс
Говь компани нь ноолууран пальтогоороо “2015 оны
салбарын онцлох бүтээгдэхүүн” өргөмжлөлийг авлаа.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Говь ХК нь хүний хөгжил, технологиор тэргүүлэн, хэрэглэгч, харилцагчдын сэтгэл ханамжыг хамгийн өндөрт хүргэж, хөрөнгө оруулагч, ажилчдын үнэ цэнэтэй байгууллага байна.

ЗОРИЛГО

4. Үйлчилгээний үлгэр жишээ соёлыг нэвтрүүлж үйлчлүүлэгч хэрэглэгчдэдээ үргэлж шинэ бүтээгдэхүүн, шилдэг үйлчилгээг хүргэнэ.

3. Байгууллагын соёлыг нэвтрүүлж, ажилтан, ажиллагсадаа бүтээлч орчин, хөгжих боломжоор хангана.

2. Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж, нийгмийн хариуцлагаа дээд зэргээр ухамсарлан нийгмийн сайн сайхны төлөөх бүхий л үйл ажиллагааг дэмжин ажиллана.

1. Говь ХК дэлхийд танигдсан монгол брэнд учир үйл ажиллагаагаа өдрөөс өдөрт эрчимжүүлэн хөгжүүлж, хэрэглэгчдийнхээ эрэлт хэрэгцээг мэдэрч дэлхийн ноолууран хувцасны зах зээлд тэргүүлэгч болно.

ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

1. Франчайзингийн бодлогыг сайжруулж, гадаад зах зээлд чиглэсэн маркетингийн ажлыг нэмэгдүүлэх, гадаад дахь Говь нэрийн дэлгүүрийн тоог 100 хүргэх (Европ, Орос, АНУ, Япон, Хятад, Солонгос)
2. Улирал харгалзахгүй өмсөх ноолуурын бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийж, ноолууран бүтээгдэхүүний шинэ зах зээл бий болгох
3. Бүтээгдэхүүний загвар, дизайн, чанарыг сайжруулах замаар бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулж, дотоод зах зээлд эзлэх хувиа өсгөх
4. Зорилтот зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүний сегментчилэлийг бий болгож, тансаг зэрэглэлийн бренд, ажил хэрэгч хувцасны дэд брендүүдийг хөгжүүлэх
5. Бүтээгдэхүүний чанарын удирдлагын тогтолцоог сайжруулж, 2015 онд батлагдсан ОУ-ын чанарын ISO9001:2015 стандартыг 2017 он гэхэд нэвтрүүлэх
6. Хөдөлмөр, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тогтолцоог сайжруулж, аюулгүй ажиллагаагаар улсын хэмжээний үлгэр жишээ компани болох, ISO18001:2015-ийг нэвтрүүлэх
7. Хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх, хүчийн чадлын ашиглалтыг сайжруулах

2016 ОНЫ ЗОРИЛТУУД

1. Франчайзингийн бодлогоо сайжруулах, гадаадад “Говь” брэндийн 10 дэлгүүр шинээр нээх
2. Гадаад маркетингыг эрчимжүүлэн, стратегийн томоохон харилцагчдын тоо, борлуулалтын хэмжээг нэмэгдүүлэх
3. Дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар бүхий улирал харгалзахгүй хэрэглэх ноолууран бүтээгдэхүүний судалгаа, хөгжүүлэлтэнд анхаарах
4. Хотын төвд хуучин хэвлэх үйлдвэрийн барилгын суурин дээр баригдах “Галлерей Улаанбаатар” цогцолборт тансаг зэрэглэлийн ноолуурын бренд бүтээгдэхүүн борлуулж эхлэх
5. Говь компанийн технологийн давуу байдлын илэрхийлэл болох онцлох бүтээгдэхүүнүүдийн борлуулалтыг нэмэгдүүлж, дотоодын зах зээлд пальто 14000 ширхэг, принттэй шааль 15000 ширхэгийг борлуулах, шинээр куртка, цув, өмд үйлдвэрлэж худалдаанд гаргах
6. Хавар/зуны болон намар/өвлийн коллекц, баяр ёслол, онцгой үйл явдлуудад зориулсан коллекц, дэд брендүүдийн коллекцуудыг гарган бүтээгдэхүүний загварыг шинэчлэх
7. Японы 65 жилийн оёдлын туршлага бүхий Лапин компани болон тансаг зэрэглэлийн пальто хослолоор мэргэшсэн Японы алдарт маэстро Каваками Казүгоор удирдуулсан Алдекс компаниудтай хамтын ажиллагааны хүрээнд оёмол бүтээгдэхүүний загвар, үлгэр суулт, технологийг дэлхийн жишигт хүргэх
8. Дэлхийд “Ширхэгтийн хаан” хэмээн алдаршсан ноён Кондо Кеничи-тэй хамтран ээрэх, нарийн ээрэх, будах, сүлжих, нэхэх үйлдвэрлэлийн технологи болон чанарын хяналтын тогтолцоог сайжруулах
9. Golden mix утасны чанарыг сайжруулан , коллекцийг хөгжүүлэх
10. Үйлчилгээний стандартыг боловсронгуй болгож, чанарыг сайжруулах
11. Үйлдвэрлэлийн шат дамжлагуудын хөдөлмөр зохион байгуулалт, үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлснээр бүтээмжтэй уялдуулан ажилчдын цалинг нэмэгдүүлэх
12. Эргэлтийн хөрөнгийг өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлэх

КОМПАНИЙН 2015 ОНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2015 оны төлөвлөгөө	2015 оны гүйцэтгэл	төлөвлөгөөний биелэлт хувь	2016 оны төлөвлөгөө	Өмнөх оноос өсөлт	
						тоо	хувь
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	сая.төг	78,118	71,211	91%	81,246	10,035	14%
Үүнээс: Дотоод борлуулалт	сая.төг	48,364	43,137	89%	49,216	8,263	19%
Үүнээс: Гадаад борлуулалт	сая.төг	29,755	28,074	94%	32,030	3,124	11%
БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ	сая.төг	40,096	43,273	108%	49,831	6,558	15%
НИЙТ АШИГ	сая.төг	38,022	27,938	73%	31,415	3,478	12%
Үйл ажиллагааны зардал	сая.төг	15,821	16,449	104%	16,711	263	2%
Үйл ажиллагааны бус ашиг алдагдал	сая.төг	(149)	2,164	-1449%	1,343	(821)	-38%
Татварын өмнөх ашиг	сая.төг	17,053	13,653	80%	16,047	2,394	18%
ЦЭВЭР АШИГ	сая.төг	14,954	10,748	72%	12,485	1,737	16%
цэвэр ашгийн хувь	хувь	19%	15%	79%	15%	0%	0.02
Экспорт	мян.USD	15,792	14,406	91%	15,562	1,157	8%
Нийт үйл ажиллагааны зардал	сая.төг	55,917	59,722	107%	66,542	6,821	11%
Нийт орлогын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	0.72	0.84	117%	0.82	-2%	-2%
ҮЙЛДВЭРЛЭЛТ	сая.төг	63,845	63,059	99%	66,212	3,153	5%
Сүлжмэл	мян.шир	531	411	77%	461	50	12%
Нэхмэл	мян.метр	185	219	118%	270	51	23%
Оёмол	мян.шир	30	27	90%	36	9	32%
Ээрмэл	тонн	226	181	80%	228	48	26%
үүнээс: Бүдүүн ээрмэл	тонн	220	175	80%	222	47	27%
Нарийн ээрмэл	тонн	6	5	89%	6	1	19%
Самнасан ноолуур, ноос	тонн	235	159	68%	178	19	12%
ТҮҮХИЙ ЭД БЭЛТГЭЛИЙН ӨРТӨГ	сая.төг	30,449	24,142	79%	16,591	(7,551)	-31%
ТҮҮХИЙ ЭД БЭЛТГЭЛ	тонн	433	472	109%	360	(112)	-24%
Ноолуур	тонн	385	406	105%	300	(106)	-26%
Тэмээний ноос	тонн	28	48	176%	50	2	3%
Сарлагийн хөөвөр	тонн	20	17	86%	10	(7)	-42%
Ноолуурын дундаж үнэ	мян.төг	81	58	72%	53	(4)	-8%
Тэмээний ноосны дундаж үнэ	мян.төг	10	7	67%	7	0	1%
Сарлагын хөөврийн дундаж үнэ	мян.төг	16	17	106%	21	4	24%
АЖИЛЛАГСДЫН ДУНДАЖ ТОО	хүн	1,392	1,264	91%	1,332	68	5%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	сая.төг	2,094	7,354	351%	4,401	(2,953)	-40%


САНХҮҮГИЙН ХАРЬЦААНУУД

САНХҮҮГИЙН ХАРЬЦААНУУД	2013	2014	2015
Зах зээлийн үнэлгээ /төг/	43,140,221,250	58,118,381,250	66,153,540,000
Гаргасан хувьцааны тоо /ширхэг/	7801125	7801125	7801125
Чөлөөтэй арилжаалагдаж буй хувьцааны тоо /ширхэг/			
Хувьцааны үнэ, арилжаалагдсан тоо			
Оны эцэст хувьцааны үнэ /төг/	5,530	7,450	8,480
52 долоо хоногийн хамгийн их /төг/	6,000	9,500	12,000
53 долоо хоногийн хамгийн бага /төг/	3,760	5,305	7,100
Арилжаалагдсан тоо /ширхэг/	250,997	53,753	43,631
Арилжааны үнийн дүн /төг/	1,192,826,544	380,373,525	362,709,570
Хувьцааны дундаж үнэ /төг/	4,752	7,076	8,313
Хувьцааны үнэлгээ			
Хувьцааны үнэ / нэгж хувьцаанд ногдох ашиг	5.26	5.26	6.03
Хувьцааны үнэ / нэгж хувьцаанд ногдох борлуулалт	0.76	0.84	0.91
Хувьцааны үнэ / дансны үнэ	0.86	1.05	0.95
Нэгж хувьцаанд ногдох:			
Ашиг	904	1,345	1,378
Борлуулалт	6,250	8,452	9,128
Өөрийн хөрөнгө	5,520	6,735	8,778
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	832	2,081	2,309
Ногдол ашиг			
Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг / хувьцааны үнэ	3%	2%	2%
Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг /төг/	130	140	140
Ногдол ашиг/ Цэвэр ашиг	14%	10%	10%
Менежментийн үр өгөөж			
Өөрийн хөрөнгийн өгөөж	0.16	0.20	0.16
Нийт хөрөнгийн өгөөж	0.09	0.10	0.09
Хөрөнгө оруулалтын өгөөж	0.09	0.13	0.12
Төлбөрийн чадвар			
Түргэн хөрвөх харьцаа	1.24	0.86	0.59
Төлбөр барагдуулах өнөөгийн боломж	9.43	3.50	2.77
Урт хугацаат өр төлбөр, эзний өмчийн харьцаа	0.76	0.54	0.35
Өр төлбөр, эзний өмчийн харьцаа	0.89	0.90	0.79
Ашигт ажиллагаа			
Нийт ашгийн хувь	40.8%	39.9%	39.2%
Цэвэр ашгийн хувь	14.5%	15.9%	15.1%

ТҮҮХИЙ ЭД БЭЛТГЭЛ /2002-2015 ОН/



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ




БОРЛУУЛАЛТ /ОНООР/



ЦЭВЭР АШИГ&ХУВЬЦАА ҮНЭ /ОНООР/

сая төгрөг



CAPEX /2007-2015/

тэрбум төгрөг



Хувьчлалаас хойш компани нийт 31,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, тоног төхөөрөмжөө шинэчлэн, технологио сайжруулсан байна.

ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭ

2015 оны 9 сард Гроут финанс аудит ХХК-аар компанийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг хийлгэсэн. Говь ХК-ийн барилга байгууламжийг дахин үнэлэхэд Үнэлгээний олон улсын стандартын дагуу элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн болон зах зээлийн жишиг үнийн хандлагыг хослуулан ашигласан бөгөөд байгууламжийн үнэлгээнд томосгосон төсвийн үнэлгээний аргыг ашигласан. Нийт барилга байгууламжийн үнэлгээ 22,299,973.7 мян.төг болсон байна.

Үүнтэй холбоотойгоор хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 6,276,052 мянган төгрөгөөр үл хөдлөх хөрөнгийн өртөг нэмэгдсэн.

АМЁБ МЕНЕЖМЕНТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН МЭДЭЭ

РС




Орлого болон зарлага нь ил тод, тодорхой, ашгаа хянах боломжтой нэгж бүтцийг хэлнэ. Ашгийн төв нь өөрөө зах зээлээ мэдэрч ашгийн төлөө ажилладаг.

НРС



Компаний ашиг олох үйл ажиллагаанд шууд бус оролцоотой ажилладаг. Ашгийн төвүүдээ дэмжих зорилготой нэгж юм.



Нэг хүнд ноогдох үйлдвэрлэл

2014
3,621,647₮

2015
4,157,377₮

Нэг хүнд ноогдох борлуулалт

2014
4,159,385₮

2015
4,666,006₮



PDCA ЦИКЛ

Амёб нэгжүүд өөрийн үндсэн үүрэгт суурилсан үйл ажиллагааны төлөвлөгөөг сар бүр боловсруулан уг төлөвлөгөөнд хүрэхийг зорин ажилладаг. Тухайн сарын төлөвлөгөөг биелүүлэхийн тулд ажлаа байнга хянаж, сайжруулах шаардлага гардаг бөгөөд энэ бүхнийг pdca циклийг ашиглан хийдэг.



ҮР АШГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРАЛ

Амёб нэгж нь нэг сарын турш ажиллахад компанид хэдий хэмжээний үр ашгийг бий болгосноо ажилчидтайгаа хэлэлцэх хурал юм. Уг хурлыг сард нэг удаа хийдэг боловч төлөвлөгөөндөө хүрч ажиллахын тулд ажлаа байнга хянаж байх шаардлагатай гэж үзэн долоо хоног тутам хийдэг болсон.



АМЁБ ЛИДЕР КЛУБ

Нэгжийн удирдлагуудаар гишүүнчлэлээ бүрдүүлсэн дотроо сургалтын баг, идэвхжүүлэлтийн баг, гадаад харилцааны баг, мэдээллийн баг гэсэн 4 баг бүрдүүлж компанийн хэмжээнд хүн бүрд хүрч ажиллах зорилготой нийт 93 гишүүнтэйгээр тогтмол үйл ажиллагаа явуулдаг клуб.



НЭГЖИЙН ҮР АШГИЙН ТОГТОЛЦОО ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Амёб менежментийн хэрэгжилтэд зориулан боловсруулсан уг журмыг компани нийтээр мөрдөн үйл ажиллагаагаа явуулдаг



СУРГАЛТ

Амёб менежментийн үзэл санаа, философи, хэрэгжилтийн талаарх 4 үе шат бүхий сургалтаар компанийн нийт ажилчдын амёб менежментийн талаарх ойлголтыг нэмэгдүүлсэн. Эдгээр сургалтууд нь цаашид ч мөн шинэ болон дэвшин ажиллаж байгаа ажилчдад зориулан хийгдсээр байх болно.



АЯН

Улирал тутам нийт компанийн хэмжээнд зохион байгуулдаг уг аян нь ажилчдын хоорондын харилцаа болон хэлтэс, нэгжүүдийн хоорондын уялдаа холбоог сайжруулах тэдгээрийг идэвхжүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлдэг.



ХЭЛТЭС НЭГЖҮҮДИЙН ХООРОНДЫН УЯЛДАА ХОЛБОО

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахад дамжлага тус бүрийн хоорондын уялдаа холбоо, мэдээлэл солилцоо хамгийн чухал байдаг тул долоо хоног тутам газрын захирлууд болон шаардлагатай албан тушаалтнуудыг цуглуулан үйлдвэрлэлийн процессын хурал хийдэг.




ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ

Амёб менежмент амжилттай хэрэгжихэд ажилтан нэг бүрийн оролцоо хамгаас чухал тул тухайн ажилтны мэдлэг, ур чадвар байнга өсөн нэмэгдэж байх шаардлагатай. Тиймээс хүн бүр өөрийгөө дайчилж дотроосоо шатаж ажиллах хэрэгтэй гэдгийг ажилчид ухамсарладаг болсон



ХҮРЭХ ҮР ДҮН

‘Говь’ хк-д амёб менежмент хэрэгжсэнээр компанийн нийт ажилчид бие болоод сэтгэлийн аз жаргал эдэлж, ажилдаа дурлан илүү өндөр бүтээмжтэй ажиллаж түүний үр дүнд компанийн ашиг орлого нэмэгдэнэ.



ЭХ ДЭЛХИЙ

Манай компанийн хүрээлэн буй орчны удирдлагын бодлого, үйл ажиллагааны зорилго нь хүний эрүүл мэндийг дээдэлсэн, байгаль орчныг бохирдуулахгүй, нийгэмд сөрөг үр дагавар авчрахгүй нээлттэй үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад оршино. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бид дараах ажлуудыг хийж байна.

ЭКО БҮТЭЭГДЭХҮҮН

Байглийн гаралтай органик ноолуурыг будаг, химийн бодис хэрэглэлгүй эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн Говь Органик Кашмер дэд брендийг бий болгосон.

REDUCE

IT ZONE компанитай хамтран хүний нөөцийн Green ERP програмыг нэвтрүүлснээр нэгдүгээрт, байгаль дэлхий модоо хайрлаж цаасны хэрэглээг багасгах, хоёрдугаарт, ажилтан бүр өөрийн цахим хувийн хэрэгтэй болж өөрийн мэдээллийг болон компанийн нийтэд хамааралтай мэдээ, мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр авдаг болсон.

Ус, дулаан, цахилгааны үргүй ашиглалтыг бууруулах зорилгоор 3 шатлалт тооллуурын систем рүү шилжин, зарцуулалтыг хянаж, дотооддоо журам боловсруулан мөрдөж ажиллаж байна.

REUSE

Компанийн хэмжээнд хаягдал цаасыг дахин болосруулж бичгийн цаас, сальфетка, нойлын цаас болгуулан дахин ашиглаж байна.

Үйлдвэрээс гарсан гол утас, үзүүр утас зэрэг технологийн хаягдлыг дахин задалж, ноолууран хөнжил, куртик зэрэг бүтээгдэхүүн хийж борлуулж байна.

Үйлдвэрт ашиглагдахгүй болж актлагдсан тоног төхөөрөмжийн хаягдлаар үйлдвэрийн дамжлага дунд ашиглах тэргэнцэр, багаж хэрэгсэл хийж дахин ашиглаж байна.

RECYCLE

Үйлдвэрлэлд ашигласан бохир усаа 2 шатлал бүхий цэвэршүүлэх шүүгчээр шүүж зөвшөөрөгдөх нормд хүртэл цэвэршүүлэн, төвийн бохирын систем рүү нийлүүлдэг. Сар бүр төвлөрсөн сүлжээнд нийлүүлж байгаа бохир уснаас сорьц авч УСУГ-н лабораторид шинжлүүлдэг.

ЭРДЭНЭТ ХҮМҮҮН

АЖИЛЛАГСАДЫН ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ


ОРОЛТЫН КОЭФИЦИЕНТ

0.23

ГАРАЛТЫН КОЭФИЦИЕНТ


0.21

НАСЖИЛТЫН ПИРАМИД



АЖИЛЧДЫН ХҮЙСНЫ ХАРЬЦАА

ХҮҮХЭД АСРАХ ЧӨЛӨӨ



АЖИЛЛАЖ БАЙГАА ЧИГЛЭЛ



Үйлдвэрийн чиглэл
866 ажилтан



Худалдаа борлуулалт чиглэл
147 ажилтан



Загвар, дизайн чиглэл
28 ажилтан



Чанар стандартын чиглэл
96 ажилтан



Аж ахуйн чиглэл
58 ажилтан



Захиргаа /хүний нөөц, санхүү/ чиглэл
61 ажилтан

БОЛОВСРОЛ



Дээд
боловсролтой

507



Тусгай дунд
боловсролтой

360



Суурь
боловсролтой

330



Боловсролгүй

3

Гадаад болон дотоод сургалтад
нийт давхардсан тоогоор

11,223 хүн/цаг



3653

ажилтан мэргэжлийн болон
менежменийн сургалтуудад
хамрагдсан

Нийт 146 ажилтан төрийн
дээд одон медаль болон
компанийн шагналаар
шагнагдсан байна.



2015 ОНЫ ШИЛДЭГ АЖИЛТНУУД

- Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон 1 ажилтан
- Алтан гадас одон 1 ажилтан
- Хөдөлмөрийн хүндэт медаль 2 ажилтан
- Аж үйлдвэрийн яамны тэргүүний ажилтан 32 ажилтан
- Аж үйлдвэрийн яамны хүндэт жуух бичиг 43 ажилтан
- Зам тээврийн яамны онц тээвэрчин 2 ажилтан
- НИХурлын төлөөлөгчийн жуух бичиг 1 ажилтан
- НИХурлын төлөөлөгчийн хүндэт тэмдэг 2 ажилтан
- МЗХолбооны шилдэг залуу инженер 3 ажилтан
- НХЗГБТөлөвлөлтийн газрын шилдэг залуу алтан медаль 33 ажилтан
- Хан-Уул дүүргийн 50 жилийн ойн хүндэт тэмдэг 2 ажилтан
- Компанийн хөдөлмөрийн аварга 5 ажилтан
- Компанийн оны шилдэг ажилтан 15 ажилтан



Компанийн үнэт баялаг болох ажилтан албан хаагчдынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахын тулд бид хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг хангаж ажиллах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарахаас урьдчилан сэргийлэх, ажлын байранд тавигдах эрүүл ахуйн шаардлага стандартыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэх, хяналт, зөвлөгөө, сургалтаар ханган ажиллах зорилгоор 2015 онд ХАБЭАхуйн албыг Гүйцэтгэх захирлын шууд удирдлага доор зохион байгуулж ажиллуулж эхлээд байгаа бөгөөд Байгууллагын стандарт ГЖ 53:09 буюу "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажиллуулах тухай журам"-ыг 2009 оноос мөрдөн ажиллаж байна.

ЭРҮҮЛ АШИГ

ТӨСӨВТ ТӨЛСӨН ТАТВАР ШИМТГЭЛ

Говь ХК нь Монгол улсын хууль тогтоомжийг чанд мөрдөж, улсын төсөвт 8-9 төрлийн татварыг төлдөг бөгөөд компанийн үйл ажиллагаа өргөжиж, зах зээлээ тэлэхийн хирээр төсөвт төлж буй татвар, шимтгэлийн хэмжээ жилээс жилд өссөөр байна.

ТӨСӨВТ ТӨЛСӨН ТАТВАР ШИМТГЭЛ



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

2015 онд нийгэмд чиглэсэн дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүллээ.

УРЛАГ СОЁЛЫН АРГА ХЭМЖЭЭГ ИВЭЭН ТЭТГЭХ

- 2015 оны 8-р сарын 11-16-ны өдрүүдэд Бразилийн Сан Паулу хотод зохион байгуулагдсан Дэлхийн ур чадварын тэмцээнд Монгол залуус анх удаа оролцсон бөгөөд “Говь” ХК тэмцээний нээлт, хаалт болон бусад үйл ажиллагаанд өмсөх 100% ноолууран гоёлыг залууст гардуулсан.
- Гандантэгчилэн хийдийн их хамба ламын эрхлэн гаргаж буй “Тэргүүн хамбын айлдвар” номын хэвлэлтийн ажилд компаниас нийт 10 сая төгрөг хандивлав.
- Эх дэлхийн Мисс 2015 тэмцээнд Монгол улсаа төлөөлөн оролцсон Баярцэцэгийг ёслолын болон үндэсний хувцсаар ивээн тэтгэсэн бөгөөд тэрээр шилдэг 16 оролцогчийн нэгээр шалгарч, 3 алт, 1 хүрэл медаль, шилдэг илтгэлээр шалгарсан.

ТЭНХЛҮҮН ЯВАХАД ТЭМЭЭГЭЭР ТУСАЛСНААС ТЭВДЭЖ ЯВАХАД ТЭВНЭЭР ТУСЛАХ

- 2015 оны 10-р сард Монголын залуучуудын холбооны “Хариу нэхээгүй тус” аяны хүрээнд Сэлэнгэ аймгийн Орхон голын үерт амь насаа алдсан Н.Саранчимэг эмэгтэйн өнчирч хоцорсон хүүхдүүд болох 8 настай У.Ууганбаяр, 6 настай У.Батсүх нарт иж бүрэн дулаан хувцас бэлэглэсэн.
- 2015 оны хавар зүүн гурван аймагт гарсан гал түймэрт өртөж, мал, орон гэргүй болсон Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын 40 айлд оёмол ноолууран хөнжил бэлэглэсэн.

ХҮҮХДИЙН САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ

- 2015 оны 10-р сард Хүүхэд асрах “Эрдэм” төвийн 22 бяцхан хүүхдэд дулаан өвөлжих хөнжил бэлэглэсэн.
- Монголын Дауны холбооны бяцхан хүүхдүүдэд шинэ жилийн бэлэг болгож, ноолууран бүтээгдэхүүнээ гардуулсан.
- Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн сан, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнтэй хамтран ажилчдынхаа хүүхдүүдийн эрүүл мэнд, өсөлт хөгжил, боловсролд анхааран эцэг, эхчүүдийн цуврал сургалтыг зохион байгуулж байна.

БОЛОВСРОЛТОЙ, АЖИЛТАЙ МОНГОЛ ХҮН

- Хөдөө аж ахуйн их сургуулиас зохион байгуулдаг 2015 оны Менежментийн улсын 7-р олимпиадад тэргүүлсэн оюутнуудад өөрийн бүтээгдэхүүний дээжээс бэлэглэсэн.
- Салбарын хөгжилд хувь нэмэр болгож дадлагажуулж сургасан оюутны тоо 159, ажилд орсон тоо 27

ДЭМ ДЭМЭНДЭЭ

- Үндэсний өгөх өдөртэй холбогдуулан компанидаа дэм дэмэндээ аяныг зохион байгуулан олон жил үр бүтээлтэй ажилласан 3 ажилтны өвчтэй хүүхдийн эмчилгээний төлбөрт хандив өргөсөн.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАР ДИЗАЙН

КОЛЛЕКЦУУД

2015 онд манай компани үндсэн 12 болон дагалдах бусад коллекцууд нийтдээ 20 гаруй коллекцоор 136 нэр төрлийн 5867 шинэ загварыг олон размер болон өнгөний сонголттой үйлдвэрлэн худалдаанд гаргалаа.






ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

“Говь” ХК –ийн мэргэшсэн чадварлаг, хамт олон хэрэглэгч, үйлчлүүлэгчиддээ дээд зэргийн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхэд авьяас чадвараа дайчлан ажиллахыг эрмэлздэг.

- Жил бүр уламжлал болгон гаргадаг ХАВАР/ЗУН, НАМАР/ӨВӨЛ-ийн коллекци
- Цагаан сар, Үндэсний их баяр наадмын загварууд, торомны ноосон бүтээгдэхүүний, хүүхдийн гээд олон коллекциудыг цаг тухайд нь худалдаанд гаргасан.

Сүүлийн жилүүдэд шинэ коллекцууддаа дэлхийн загварын хөгжил, чиг хандлагад орж ирсэн шинэ хийц маягийг бид нилээд түлхүү ашигласан ба үүнд:

- Олон төрлийн материалыг хослуулах тэр дундаа торго, шиффон, тор зэрэг материалыг бүтээгдэхүүндээ хослуулсан загварууд
- принт буюу төрөл бүрийн хээ, өнгөний хязгааргүй сонголтоор хэвлэж чимэглэсэн алчуур болон бусад бүтээгдэхүүнүүд
- Шигтгээ /Swarovski болон Swarovski elements-компаниудтай албан ёсоор хамтран ажилладаг/ сувд, шүрэн чимэглэлтэй алчуур болон бусад хувцас бүтээгдэхүүнүүд
- Хятад болон Итали улсуудаас захиалдаг үнэг, туулай зэрэг амьтны жинхэнэ үстэй загварууд
- 2 Талтай драпан пальто
- Ажил хэрэгч залуучуудад зориулсан ноолууран брюкэн өмд



БРЕНДҮҮД

GOBI ORGANIC

MONGOLIAN CASHMERE

Ноолуурын байглийн үндсэн 4 өнгө болох цайвар, цайвар шаргал, хөх саарал, бор өнгүүдийг ашигласан, будаагүй, цайруулаагүй, химийн ямар ч орц ороогүй Gobi Organic Cashmere бренд

SUMMER LIGHT CASHMERE

Тансаг зэрэглэлийн нарийн ноолууран утсаар сүлжиж, ноолуурын шинж чанартай гайхалтай зохицдог, тор, саан утас, торгон материалыг хослуулан, хатгамал хээгээр чимсэн дэгжин, хөнгөн Light Cashmere бренд



Гольф сонирхогч, тамирчидад зориулан тансаг ноолуураар өнгөний гайхамшгийг хослуулан урласан GOBI GOLF бренд



АЛТАН ХОЛЬЦ
NEW COLLECTION

Японы мэргэжлийн технологичдын олон жилийн туршлага, байгалийн тансаг ширхэгтүүдийн зохимжит харьцаа, загварлаг өнгөлөг бүхний нийлбэр Golden mix бренд



Хүүхдийн хөдөлгөөнд саадгүй, хөнгөн, зөөлөн, загварлаг Мазаахай хүүхдийн бренд

ЧАНАР

Манай компани бүтээгдэхүүнээ олон улсын ISO 9001:2008/MNS ISO 9001:2010 ,ISO/ IEC 17025 стандартын шаардлагын дагуу үйлдвэрлэж, баталгаажуулан дотоод, гадаадын хэрэглэгчдэд хүргэдэг бөгөөд хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэхээр үйлдвэрлэлийн шат дамжлага бүрээр чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн, чанарын 60 гаруй MNS стандарт , компанийн дотоод 32 журам, стандарт, ажлын зааварчилгааг мөрдөж, 100% чанарын хяналт шалгалтыг хийж, чанарын хяналтын тогтолцоог тасралтгүй сайжруулан ажиллаж байна.



1994 онд- ISO 9001 олон улсын стандарт Чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж анхны №01 гэрчилгээ



1997 онд- “Үндэсний тохирлын тэмдэг” тэмдэг хэрэглэх гэрчилгээ



1999 онд- ISO/IEC 17025:2005 (MNS ISO/ IEC 17025:20007) стандартын шаардлага хангасан “Хэмжих хэрэгслийн лаборатори ”



1999 онд - ISO/IEC 17025:2005 (MNS ISO/ IEC 17025:20007) стандартын шаардлага хангасан “Нэгдсэн лаборатори”

БОРЛУУЛАЛТЫН ДАРААХ ҮЙЛЧИЛГЭЭ

Компани Хими цэвэрлэгээ, нөхөн засварын албыг ажиллуулж ноолууран бүтээгдэхүүний мэргэжлийн цэвэрлэгээ, засвар үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд өөрийн компанийн бүтээгдэхүүнд байнгын хөнгөлөлттэй үнийг санал болгодог.

АРИЛЖААНИЙ МЭДЭЭЛЭЛ

Говь ХК-ийн хувьцаа нь сүүлийн жилүүдэд тасралтгүй Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индексийн багцад орж байгаа бөгөөд 2016 оны эхний хагас жилд ТОП-20 индексийн багцыг бүрдүүлэх үнэт цаасуудыг сонгон шалгаруулахад Говь ХК-ийн үнэт цаас нь Арилжаанд орсон хоногийн тоогоор 2-рт, Зах зээлийн үнэлгээгээр 3-рт, Өдрийн дундаж гүйлгээгээр 4-рт жагссан байна.

“Говь” ХК-ийн хувьцааны 2015 оны арилжааны мэдээ:

Гаргасан хувьцааны тоо, төрөл 7 801 125 ширхэг энгийн хувьцаа

52 долоо хоногийн хувьцааны арилжааны ханш

Доод ханш	7,160
Дээд ханш	11,830
Дундаж ханш	8,313
Хаалтын ханш	8,480
Арилжигдсан тоо хэмжээ	43,631 ширхэг
Арилжааны үнийн дүн	362,709,570 төгрөг
Зах зээлийн үнэлгээ	66,153,540,000 төгрөг

2015 ОНЫ ХУВЬЦААНЫ АРИЛЖАА



ТОМ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

2016 оны 1 дугаар сарын 31-ний байдлаар “Говь” ХК-ийн хувьцааг нийт 16,330 хувьцаа эзэмшигч эзэмшиж байгаа бөгөөд үүнээс нийт хувьцааны 5%-с дээш хувийг эзэмшиж байгаа 4 том хувьцаа эзэмшигчийг доорх хүснэгтээр харуулав.

Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо /мян.ш/	Эзэмшлийн хувь
HIDE INTER LLC	2,652.3	34.0%
“ЭФ-СИ-АЙ” ХХК	2,230.0	28.6%
“ТАВАН БОГД ТРЕЙД” ХХК	1,239.8	15.9%
“ҮЛЭМЖ ИХ” ХХК	439.8	5.6%

HIDE INTER LLC, “ҮЛЭМЖ ИХ” ХХК, “ЭФ-СИ-АЙ” ХХК нь Хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

“ТАВАН БОГД ТРЕЙД” ХХК нь “Таван Богд Групп”-ийн толгой компани ба 1997 онд Группийн хэмжээнд бодлого стратегийг нэгдсэн байдлаар тодорхойлох, шинэ бизнесийг нээн хөгжүүлэх, хөрөнгө оруулалт болон салбар компаниудад менежментийн дэмжлэг үзүүлэх зорилготойгоор байгуулагдсан.

Үйл ажиллагааны чиглэл:

- Гадаад худалдаа
- Дотоод худалдаа
- Хөрөнгө оруулалт
- Зочид буудал
- Аялал жуулчлал
- Нийтийн хоол



ЗАРЛАСАН НОГДОЛ АШИГ

Ногдол ашиг зарласан он	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашигт тараасан /төг/
1996	61	475,868,625
1997	154	1,199,813,025
1998	150	1,170,168,750
1999	166	1,294,986,750
2000	100	780,112,500
2001	20	157,270,680
2005	60	468,067,500
2006	60	468,067,500
2010	100	780,112,500
2011	100	780,112,500
2012	125	975,140,625
2013	130	1,014,146,250
2014	140	1,092,157,500
2015	140	1,092,157,500

2014 ОНЫ НООГДОЛ АШИГ ТАРААЛТЫН ТАЙЛАН

2014 онд зарласан ногдол ашиг	Компани дээрээ тараасан	91	6,899,807	965,972,980
	ҮЦТТХТ-өөр зуучлуулан тараасан	16,458	901,318	126,184,520
	НИЙТ	16,549	7,801,125	1,092,157,500


2015 ОНД ЗАРЛАСАН НОГДОЛ АШИГ, ТҮҮНИЙГ ТАРААХ ЖУРАМ

2016 Компани нь дотоодын зах зээлд байр сууриа хадгалах, улмаар зах зээлд эзлэх хувиа өсгөх, гадаад зах зээлээ тэлэхийн тулд техник, технологио шинэчлэх, бүтээгдэхүүний чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн, чанарыг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр чармайн ажиллахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын өгөөжийг өсгөж, хувьцаанд ногдол ашиг тараахыг эрмэлзэж байгаа билээ.

Иймээс компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2016 оны 1 сарын 21-ны өдрийн хурлаар 2015 оны үр дүнгээс хувьцааны нэгж тутамд 140 төгрөгийн ногдол ашиг буюу цэвэр ашгийн 10.3 хувийг ногдол ашигт тарааж, үлдсэн хэсгийг тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, түүхий эд бэлтгэлд зарцуулахаар шийдээд байна.

2015 оны ногдол ашгийг 2016 оны 6 сарын 1-ний өдрөөс эхлэн компани дээрээ тарааж, үлдсэн хэсгийг 2016 оны 10 сарын 1-нээс өмнө Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх болно.

ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА



Компани нь шинэчилэн батлагдсан Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодекс, гадны компаниудын сайн засаглалын туршлагаас суралцан Сайн засаглалыг нэвтрүүлэх, компанийн засаглалаар манлайлахаар чармайн ажиллаж ирсэн бөгөөд Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг идэвхжүүлэхээр Компанийн засаглалын үндэсний зөвлөл /КЗҮЗ/, Монголын хөрөнгийн бирж /МХБ/-ээс санаачилсан “Сайн засаглалтай хувьцаат компани болохоор хичээж ажиллах ТҮНХАГ БИЧИГ”-т нэгдэн ажиллаж байна.

2014 онд Говь ХК нь хувьцаа нь хамгийн идэвхтэй арилжигдсан, зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр, тогтмол ашиг олгодог, мэдээллийн ил тод байдлыг ханган ажилладаг үзүүлэлтээр “Монголын хөрөнгийн бирж”-ийн “Шилдэг хувьцаат компани”-иар тус шалгарч өргөмжлөл авсан.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

2015 онд компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 4 сарын 16 өдөр 6,685,403 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид оролцож, 85.70 хувийн ирцтэйгээр, ээлжит бус хурал 6 сарын 26 өдөр 6,684,548 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид оролцож, 85.69 хувийн ирцтэйгээр тус тус хуралдаж, дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

1.Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2014 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн 100%-ийн зөвшөөрсөн саналаар баталсан.

2.Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн 100%-ийн зөвшөөрсөн саналаар баталсан. Дүрэмд дараах өөрчлөлтүүдийг оруулсан.

-“6.11 ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ”

-“6.48 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байх бөгөөд өөр компани, аж ахуйн нэгжийн гүйцэтгэх удирдлагад ажиллаж болно”

-“7.1 ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал, Бизнес удирдлагын газрын захирал, Борлуулалтын газрын захирал, Үйлдвэр удирдлагын газрын захирал, Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн газрын захирал, Чанар стандарт баталгаажуулалтын газрын захирал, Хуулийн зөвлөх зэрэг албан тушаалтныг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно”

-“8.3 Компани НББ хөтөлж, санхүүгийн тайлан гаргах бөгөөд түүний үнэн зөвийг Санхүү бүртгэлийн хэлтсийн захирал, Гүйцэтгэх захиралтай хамтран хариуцна”

3.ТУЗ-н гишүүнд нэр дэвшигчдийг сонгож, батламжлах асуудлын хэлэлцэн Цагаачийн Баатарсайхан, Дашдаваагийн Хулан, Такеши Камбе, Хидео Савада, Даваагийн Наранбаатар,Түнрэвийн Одмаа, Дамбийжавын Хүрэлбаатар, Дамбын Гэрэлмаа, Цагаачийн Отгонбаатар нарыг улируулан сонгох шийдвэр гаргалаа .

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ-өөс жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг сар тутмын тайлангаар хянан, холбогдох үүрэг, чиглүүлгийг өгч ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд компани сайн засаглалыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд ТУЗ-ийн ажиллах журам, аудитын хороо, цалин урамшууллын хорооны дүрэм, хараат бус аудиторт тавигдах шалгуур, дотоод аудитын хэлтсийн үйл ажиллагааны горимууд, эрх бүхий албан тушаалтнуудын ажлын байрны тодорхойлолт, гүйцэтгэлийн үнэлгээ, ТУЗ-ийн өөрийгөө үнэлэх механизм, мэдээллийн нууцын журам зэргийг батлан мөрдөж байна.

Мөн хууль, журам, засаглалын кодексийн дагуу мэдээллийг ил тод болгоход анхаарч, олон нийтэд хүргэх мэдээ, мэдээллийг тогтмол, цаг хугацаанд нь зохих журмын дагуу хүргэж ирлээ. Цаашид эдгээр үйл ажиллагаатай холбоотой журмуудаа баталж, компанийн засаглалаар тэргүүлэгч, үлгэр жишээ компани болохыг зорьж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл 5 удаа, Аудитын хороо 4 удаа, Нэр дэвшүүлэх хороо 2 удаа, Цалин, урамшууллын хороо 2 удаа тус тус ээлжит хурлаа хийж, холбогдох чиг үүргийн хүрээнд компанийн стратегийг тодорхойлж, үйл ажиллагааг чиглүүлэн, хяналт тавьж ажиллалаа.

ХАРААТ БУС АУДИТОР

Говь ХК-ийн 2015 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн тайланд Делойт Онч Аудит ХХК аудит хийсэн. Делойт нь олон улсын 4 том аудитын компанийн нэг бөгөөд 2012 оноос эхлэн Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа, 2014 онд Санхүүгийн зохицуулах хороонд Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх Аудитын компаниар бүртгэгдсэн. Гэрээт ажлын хөлс 44,000,000 төгрөг.

ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

Говь ХК-ын Дотоод аудитын хэлтэс нь ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороонд харьяалагдах бөгөөд Дотоод аудитын алба (үйл ажиллагаа), Дотоод хяналтын алба (санхүү, бүртгэл) гэсэн 2 албатайгаар үйл ажиллагаагаа явуулдаг.

Дотоод аудитын хэлтэс нь компанийн гүйцэтгэх удирдлагаас хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулах ба компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй.

Аудитын хорооноос батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг явуулж, шалгалтын үр дүнг аудитын хороондоо эргэж тайлагнадаг. Илэрсэн зөрчлийг арилгах, засаж залруулах арга хэмжээг тусгасан зөвлөмжүүдийг гүйцэтгэх удирдлагад хүргүүлэх байдлаар компанийн удирдлагын багтай холбогдон эргэх холбоотой ажиллаж байна.

УДИРДЛАГА БОЛОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАРДАЛ

ЗАРДЛЫН ТӨРӨЛ	2015 он	2014 он
ТУЗ-ийн цалин урамшуулал	102,455	102,614
Удирдлагын цалин урамшуулал	656,903	676,268
Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал	16,328	12,516

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШСЭН БАЙДАЛ

Эрх бүхий албан тушаалтны нэр	Говь ХК-ийн хувьцааг эзэмшсэн байдал	
	Дангаараа	Нэгдмэл сонирхолтой этгээдүүд
Д.ХУЛАН	122,473(1.57%)	ЭФ-СИ-АЙ ХХК 28.59% ТАВАН БОГД ТРЕЙД ХХК 15.89% ҮЛЭМЖ ИХ ХХК 5.63%
Ц.БААТАРСАЙХАН	500(0.01%)	
НИЙТ		51.68%
Д.ХҮРЭЛБААТАР	48(0.0006%)	-

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН



**Дамбийжав
ХҮРЭЛБААТАР**

ТУЗ-ийн дарга
Хараат бус гишүүн

Цалин урамшууллын
хорооны дарга



**Цагаач
БААТАРСАЙХАН**

ТУЗ-ийн гишүүн
Цалин урамшууллын
хорооны гишүүн

Гүйцэтгэх захирал



**Дамба
ГЭРЭЛМАА**

ТУЗ-ийн хараат бус
гишүүн
Нэр дэвшүүлэх
хорооны дарга
Аудитын хорооны
гишүүн



**Даваа
НАРАНБААТАР**

ТУЗ-ийн гишүүн
Нэр дэвшүүлэх
хорооны гишүүн

Тэргүүн дэд захирал



**Түнрэв
ОДМАА**

ТУЗ-ийн
хараат бус гишүүн

Аудитын хорооны
дарга



**Цагаач
ОТГОНБААТАР**

ТУЗ-ийн гишүүн



**Такеши
КАМБЕ**

ТУЗ-ийн
хараат бус гишүүн
Цалин урамшууллын,
Нэр дэвшүүлэх хорооны
гишүүн



**Хидео
САВАДА**

ТУЗ-ийн гишүүн



**Дашдаваа
ХУЛАН**

ТУЗ-ийн гишүүн


Аудитын хорооны
гишүүн



**Дугар
СОЛОНГО**

ТУЗ-ийн нарийн
бичгийн дарга

КОМПАНИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



КОМПАНИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Компани гадаад, дотоод зах зээлээ тэлж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх үүднээс гадаад, дотоод борлуулалтын сувгаа нэмэгдүүлж, маркетингийн үйл ажиллагаагаа сайжруулах, худалдан авагчидтай харилцаагаа шинэ түвшинд авчрах зорилт тавьж, 2015 оноос Борлуулалт, маркетинг хариуцсан дэд захирал-ын орон тоог шинээр бий болгосон.
- Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал-ын орон тоог шинээр бий болгож, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, үйлдвэрлэл, чанар болон эдгээр үйл ажиллагааг дэмжих бусад нэгжүүдийг нэгтгэн нэгдсэн удирдлагаар хангахаар зохион байгууллаа.
- Мөн бүтээгдэхүүний загвар, дизайныг сайжруулах, нэр төрлийг олшруулах, Говь брендийг хөгжүүлэх зорилтын хүрээнд 2015 оноос хуучин загварын алба байсныг томруулан Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн газар болгон зохион байгуулсан.
- Бүтээгдэхүүний чанарыг сайжруулах зорилтын хүрээнд Чанар стандарт баталгаажуулалтын хэлтэс гэж байсныг Чанар, стандарт, баталгаажуулалтын газар болгон томруулж, чанарын хяналтын тогтолцоог боловсронгуй болголоо.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль шинэчилэгдэн 2015 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Гүйцэтгэх захирлын шууд удирдлага дор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн алба-ыг байгуулан, дарга, ХАБЭА-н инженер, эмч, сувилагч, аюулгүй ажиллагааны хяналтын инженерүүд гэсэн 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллуулж эхэлсэн. Эдгээрээс гадна үйлдвэр, цехийн нэгжийн удирдлагууд нь өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажиллаж байна.
- Амёб менежментийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор үйлдвэр, цехүүдийг хэлтэс, алба, нэгжийн статустай болгож, ашгийн төв /РС/ болон ашгийн бус төв /NPC/-үүдэд ангилан, бие даасан үр ашгийн тооцоотой байхаар зохион байгуулаллаа.

КОМПАНИЙН УДИРДЛАГУУД



**Цагаач
БААТАРСАЙХАН**

Политехникийн их сургуулийг Холбооны инженер, Япон улсын Цахилгаан Холбоо, Электроникийн Их Сургуулийг Электроникийн инженер мэргэжлээр төгссөн. Алтай компанид Орлогч захирал, Таван Богд компани, Таван Богд Трейд ХХК, Жуулчин ХХК, МИАТ компаниудын Ерөнхий захирал, Палас зочид буудлын Гүйцэтгэх захирлын албан тушаалуудыг хашиж байсан. Таван Богд группийн Ерөнхийлөгч, Жуулчин компанийн Ерөнхийлөгч, Палас болон Хаан Палас зочид буудлын ТУЗ-ийн дарга 2008 оны 8 сараас Говь ХК-ийн Гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.



**Даваа
НАРАНБААТАР**

Худалдаа Үйлдвэрлэлийн дээд сургуулийг Нягтлан бодогч, Эдийн засагч мэргэжлээр төгссөн. Таван Богд Косметикс ХХК-д Өрөлтийн менежер, Судалгааны менежер, Ахлагч, Бизнес төлөвлөлтийн хэлтсийн дарга, Дэд захирал, 2008 оноос Говь ХК-ийн Дотоод худалдааны газрын захирлын албан тушаалыг хашиж байсан. 2009 оноос Говь ХК-ийн Тэргүүн дэд захиралаар ажиллаж байна.



**Нямжав
СҮРЭНРАГЧАА**

Япон улсын Хитоцубаши-гийн их сургуулийг Эдийн засагч мэргэжлээр магистрын зэрэгтэйгээр төгссөн. Таван богд трейд ХХК-д Төслийн мэргэжилтэн, Төслийн туслах менежерээр ажиллаж байсан. 2015 оны 4 сард Говь ХК-ийн Бизнес удирдлагын газрын захирлаар томилогдож мөн оны 11 сараас Үйл ажиллагаа хариуцсан дэд захирлаар томилогдон ажиллаж байна.



**Лувсан
АРИУН**

Япон улсын Рицүмэйкан-Ази Номхон Далайн Их Сургуулийг Маркетингийн менежерээр төгссөн. KVN Co.Ltd-д Маркетингийн менежер, KVN Co.Ltd-ийн Хонг Конг дахь салбарын Маркетингийн ахлах менежер, 2015 оны 07 сараас Говь ХК-ийн Менежмент удирдлагын хэлтэст Бодлого журам хариуцсан менежер, 2015 оны 11 сараас Борлуулалт хариуцсан дэд захирлаар дэвшин ажиллаж байна.



**Цэрэндондог
БУДХҮҮ**

ХААИС-ийг Бизнесийн удирдлага мэргэжлээр төгссөн. Монфреш ХК, Ди Си Эйч ХХК-д Маркетингийн менежер, Таван богд Смарт электроникс ХХК-д Маркетингийн менежер, Маркетинг, борлуулалтын албаны даргаар ажиллаж байсан. 2015 оны 5 сараас Говь ХК-ийн Борлуулалтын газрын захирлаар ажиллаж байна.



**Гонгор
САРУУЛЗАЯА**

Вьетнам улсын Ханойн их сургуулийг Сүлжмэлийн технологич инженер мэргэжлээр төгссөн. 2004 оноос эхлэн Говь ХК-д Дагалдан инженер, Мастер, Төлөвлөлтийн менежер, Сүлжмэлийн үйлдвэрийн даргаар тус тус ажиллаж байсан. 2014.10.сараас ҮҮГ-ын захирлаар дэвшин ажиллаж байна.



**Мандал
БАТЦЭРЭН**

УБИС-ийг Дизайнер мэргэжлээр төгссөн. 1999 оноос Говь ХК-д Загвар зохион бүтээгч инженер, Cashmere Product компанид Ахлах загвар зохион бүтээгч, Менежер, Говь ХК Ахлах дизайнер, Продакт менежерээр ажиллаж байсан. 2016 оноос Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн газрын захирлаар дэвшин ажиллаж байна.



**Нямцэрэн
ДАВААСҮРЭН**

ШУТИС-ийг ээрмэлийн технологич инженер, Мандах дээд сургуулийг Санхүү, НББ мэргэжлээр төгссөн. 2000 оноос Говь ХК-ийн Анхан шат боловсруулах үйлдвэр, Ээрэх үйлдвэрүүдэд Мастер, Ерөнхий инженер, Чанарын инженер, Үйлдвэрийн даргаар ажиллаж ирсэн. 2015 оны 2 сараас Чанар стандарт баталгаа жуулалтын газрын захирлаар томилогдон ажиллаж байна.

ГОВЬ ХК

Санхүүгийн тайлан болон хараат
бус аудиторын тайлан
2015 оны 12 сарын 31

АГУУЛГА

Хуудас

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	1
ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН	2
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	3
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	4
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	5



“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ

Улаанбаатар хот 17062, Хан-Уул дүүрэг,
3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Утас: 342713
Факс: 343081, УБ-36 Ш/х №434
И-мэйл: info@gobi.mn, Вэб сайт: www.gobi.mn
УБД:9010001061

2016.02.26 № 01/103
танай _____-ны № _____-д

2016 оны 2 дугаар сарын 26

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

Цагаач овогтой Баатарсайхан би Говь ХК-ийн гүйцэтгэх захирлын хувьд, Ганболд овогтой Сэлэнгэ би тус Компанийн Санхүү Бүртгэлийн Хэлтсийн захирлын хувьд ард хавсаргасан 1-ээс 36-р хуудас дахь Говь ХК-ийн санхүүгийн тайлангуудыг холбогдох Санхүүгийн Тайлагналын Олон Стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд 2015 оны 12 дугаар сарын 31-нээрх Компанийн санхүүгийн байдал ба уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг шударгаар үзүүлж байна гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

Ц. Баатарсайхан
Гүйцэтгэх захирал

Г. Сэлэнгэ
Санхүү Бүртгэлийн Хэлтсийн Захирал

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчид танаа,

Бид Говь ХК (цаашид “Компани” гэх) -ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн иж бүрэн орлогын тайлан, өмчийн оорчлолтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний зөрчилгүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аудиторын үүрэг

Аудитор хийсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүрэгтэй. Бид аудитаа Аудитын Олон Улсын стандартын дагуу гүйцэтгэсэн болно. Санхүүгийн тайлан нь материаллаг үзүүлэлтийнхээ хувьд алдаа зөрчилгүй гэдэг зохих магадлагаа олж авахуйцаар аудитыг төлөвлөж гүйцэтгэх ба ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөхийг эдгээр стандартуудад шаарддаг.

Аудит нь санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгыг нотлох нотолгооны зүйлсийг олж авахын тулд гүйцэтгэдэг аудитын горимуудаас бүрдэнэ. Санхүүгийн тайлан алдаа болон санаатай зальт үйлдлийн улмаас материаллагаар зөрчилтэй илэрхийлэгдэх эрсдэлд өгсөн аудиторын үнэлгээнээс хамааран аудитын горимуудыг сонгодог. Аудитор эрсдэлийн үнэлгээ хийхдээ санхүүгийн тайлан бэлтгэх шударгаар тайлагнахад хэрэглэдэг дотоод хяналтыг судалдаг. Энэ нь зөвхөн тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг сонгохтой холбоотой бөгөөд аж ахуйн нэгжийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгогүй болно. Үүнээс гадна аудит нь удирдлагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой эсэх, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн урьдчилсан тооцоолол зохистой эсэх, нийт санхүүгийн тайлангийн ерөнхий тайлагналын байдлыг үнэлэх ажлуудаас бүрдлэг.

Бидний олж авсан аудитын нотлох зүйлс нь аудиторын дүгнэлт гаргах хангалттай ба зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Дүгнэлт

Бид, Компанийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайлан нь хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу зөвхөн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

Норжинбат

Шагдарсүрэнгийн Норжинбат
Захирал, МНБ
Делоитт Онч Аудит ХХК
2016 оны 2 дугаар сарын 26



ГОВЬ ХК
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2015 ОНЫ 12 САРЫН 31
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Тодруулга	2015	2014
Хөрөнгө			
<i>Эргэлтийн хөрөнгө</i>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4	18,011,349	16,236,253
Дансны ба бусад авлага	5	11,282,338	3,333,878
Урьдчилгаа төлбөр	6	8,592,030	968,833
Бараа материал	7	46,366,783	45,610,492
		84,252,500	66,149,456
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>			
Үндсэн хөрөнгө	8	38,284,770	33,411,997
Хойшлогдсон татварын хөрөнгө	16.3	209,736	389,507
Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	9	13,782	27,044
		38,508,288	33,828,548
Нийт хөрөнгө		122,760,788	99,978,004
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч			
<i>Богино хугацаат өр төлбөр</i>			
Дансны ба бусад өглөг	10	3,882,452	7,041,180
Орлогын албан татварын өглөг	16.2	508,123	520,705
Богино хугацаат банкны зээл	11	26,014,975	11,357,000
		30,405,550	18,918,885
<i>Урт хугацаат өр төлбөр</i>			
Урт хугацаат өглөг	12	-	158,659
Урт хугацаат банкны зээл	11	23,880,000	28,357,000
		23,880,000	28,515,659
Нийт өр төлбөр		54,285,550	47,434,544
Эзэмшигчдийн өмч			
Хувьцаат капитал	13	780,113	780,113
Дахин үнэлгээний нэмэгдэл		13,370,979	7,094,927
Хуримтлагдсан ашиг		54,324,146	44,668,420
		68,475,238	52,543,460
Нийт өр төлбөр ба Эзэмшигчдийн өмч		122,760,788	99,978,004

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

ГОВЬ ХК
ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2015 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Тодруулга	2015	2014
Борлуулалтын орлого	17.1	71,210,860	65,934,570
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	17.2	(43,273,032)	(39,600,414)
Нийт ашиг		27,937,828	26,334,156
Санхүүгийн ба бусад орлого	18	1,871,472	833,010
Бусад олз ба (гарз)	19	292,447	(216,163)
Хүүгийн зардал		(3,981,100)	(2,819,449)
Борлуулалт ба ерөнхий удирдлагын зардал	20	(12,467,481)	(10,749,881)
Татварын өмнөх ашиг		13,653,166	13,381,673
Орлогын татварын зардал	16	(2,905,283)	(2,889,864)
Цэвэр ашиг		10,747,883	10,491,809
Бусад иж бүрэн орлого	8.1	6,276,052	-
Нийт иж бүрэн орлого		17,023,935	10,491,809
Нэгж хувьцаанд ногдох ашиг	15	1.38	1.34

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

**ГОВЬ ХК
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2015 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт
2013 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	780,113	7,094,927	35,190,755	43,065,795
Тайлант жилийн нийт иж бүрэн орлого	-	-	10,491,809	10,491,809
Зарласан ногдол ашиг	-	-	(1,014,144)	(1,014,144)
2014 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	780,113	7,094,927	44,668,420	52,543,460
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	10,747,883	10,747,883
Бусад иж бүрэн орлого	-	6,276,052	-	6,276,052
Тайлант жилийн нийт иж бүрэн орлого	-	6,276,052	10,747,883	17,023,935
Зарласан ногдол ашиг	-	-	(1,092,157)	(1,092,157)
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	780,113	13,370,979	54,324,146	68,475,238

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

ГОВЬ ХК
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2015 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	2015	2014
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Тайлант жилийн цэвэр ашиг	10,747,883	10,491,809
Тохируулгууд:		
Элэгдэл ба хорогдлын зардал	4,008,416	3,543,227
Орлогын татварын зардал	2,905,283	2,889,864
Хүүгийн зардал	3,981,100	2,819,449
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн алдагдал	125,253	645,609
Найдваргүй авлагын зардал/(нөхөлт)	24,054	(3,096)
Удаан гүйлгээтэй барааны хасагдуулгын нөхөлт	(68,714)	(386,945)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны (олз)/гарз	(462,778)	91,065
	<u>21,260,497</u>	<u>20,090,982</u>
Дансны ба бусад авлагын өөрчлөлт	(558,294)	(1,321,312)
Урьдчилгаа төлбөрийн өөрчлөлт	(7,760,101)	(121,907)
Бараа материалын өөрчлөлт	(687,578)	(17,051,491)
Дансны ба бусад өглөгийн өөрчлөлт	(3,254,105)	1,301,247
	<u>9,000,419</u>	<u>2,897,519</u>
Төлсөн орлогын татвар	(2,601,190)	(2,631,909)
Төлсөн хүү	(4,038,327)	(2,881,723)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	2,360,902	(2,616,113)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Үндсэн хөрөнгө борлуулснаас орж ирсэн мөнгө	6,829,056	8,911
Худалдан авсан үндсэн хөрөнгө	(8,954,875)	(5,677,385)
Худалдан авсан бусад эргэлтийн бус хөрөнгө	(3,278)	(3,519)
Холбоотой талд өгсөн санхүүжилт	(17,397,789)	(13,500,700)
Холбоотой талд өгсөн санхүүжилтээс төлөгдсөн дүн	10,000,000	25,342,300
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(9,526,886)	6,169,607
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Авсан зээл	18,000,000	10,000,000
Төлсөн зээл	(7,957,000)	(2,791,294)
Төлсөн ногдол ашиг	(1,093,331)	(1,014,761)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	8,949,669	6,193,945
Мөнгөний үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл	(8,589)	1,527
Мөнгөн хөрөнгийн өсөлт	1,775,096	9,748,966
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	16,236,253	6,487,287
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,011,349	16,236,253

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

**ГОВЬ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2015 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

1. Үндсэн үйл ажиллагаа ба зохион байгуулалт

Говь ХК (цаашид "Компани" гэх) нь 1981 онд Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан. Компаний нийт хувьцааны 28.59% -ийг Эф Си Ай ХХК, 34%-ийг Хида Интер ХХК, 15.89%-ийг Таван Богд Трейд ХХК эзэмшдэг ба үлдсэн 21 хувь нь Монголын хөрөнгийн биржээр арилжаалагддаг.

Компани 2014 болон 2015 оны 12-р сарын 31-ээрх дуусгавар болсон жилд сүлжмэл ба нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулах үйл ажиллагааг явуулсан.

2015 онд Компани нь дунджаар 1,264 үндсэн ажилтантай ажилласан (2014 онд 1,321).

Компанийн албан ёсны хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо Говь Хувьцаат Компанийн байр болно.

Компанийн удирдлага аудитлагдсан санхүүгийн тайланг 2016 оны 2-р сарын 26-нд баглан гаргасан.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй

2.1 Мөрдсөн стандарт

Компанийн санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын (СТОУС) дагуу тууштай бэлтгэж, тайлагнасан болно.

2.2 Санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь

Санхүүгийн тайланг зарим үндсэн хөрөнгөөс бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт үндэслэн бэлтгэсэн. Нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгаснаар зарим үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн үнэ буюу бодит үнэ цэнээр бүртгэсэн. Түүхэн өртөг нь хөрөнгийг худалдан авах үед төлсөн эсвэл солилцсон зүйлийн бодит үнэ цэна байдаг.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг компаний үйл ажиллагааны үндсэн мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр илэрхийлсэн. Санхүүгийн тайлангуудыг өөрөөр заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлсэн.

2.3 Нягтлан бодох бүртгэлийн тооцоолол

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, санхүүгийн тайлангийн өдрөөр тайлагнагдсан хөрөнгө, өр төлбөрийн дүн, болзошгүй хөрөнгө, өр төлбөрийн тодруулга болон тайлант үед хүлээн зөвшөөрөгдсөн орлого, зардлын дүнд тус тус нөлөөлдөг. Ирээдүйд гарах бодит үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн таамаглал, төсөөллийг байнга хянадаг. НББ-ын тооцоололд хийсэн өөрчлөлтийг өөрчлөлт хийгдсэн тайлант үе болон ирээдүйн тайлант үеүүдэд тус тус тусгадаг.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн тооцоолол (үргэлжлэл)

Дараах санхүүгийн тайлангийн их хэмжээний дүн бүхий үзүүлэлтүүдийн таамаглал төсөөллийг ашиглан, санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн.

2.3.1. Дансны ба бусад авлагын эргэн төлөгдөх байдал

Компани тайлант хугацааны эцэст дансны ба бусад авлагын эргэн төлөгдөх байдлыг хянадаг. Компани дансны ба бусад авлагын эргэн төлөгдөх магадлалыг тухайн авлагын насжилт, уг харилцагчийн зээлийн түүх болон санхүүгийн гүйцэтгэлд үндэслэн тооцоолдог.

2.3.2 Бараа материалын үнэлгээ

2.4-д тодорхойлсноор, Компани санхүүгийн тайлангийн өдрөөрх удаан гүйлгээтэй бараа материалын хасагдуулгыг дараах төсөөлөлд үндэслэн тооцоолсон.

	Сэн байгуулсан хувь
4 жилээс дээш насжилттай бэлэн бүтээгдэхүүн	100%
2 жилээс дээш, 4 жилээс доош насжилттай бэлэн бүтээгдэхүүн	50%
2 жилээс доош насжилттай бэлэн бүтээгдэхүүн	0%
4 жилээс дээш насжилттай сэлбэг хэрэгсэл, туслах материал	100%

Удирдлага дээрх бараа материалын үнэлгээг тодорхойлоход хэрэглэсэн төсөөлөл болон үнэлэмж зохистой буюу тохиромжтой гэдэгт итгэж байна.

2.3.3 Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил

2.6-д тодорхойлсноор, Компани үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцооллыг санхүүгийн тайлангийн өдрөөр хянадаг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай бол залруулдаг. Тайлант жилийн эцэст үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцоололд өөрчлөлт гараагүй.

2.3.4 Барилгын дахин үнэлгээ

Компани 2015 оны 12 сарын 31 нээрх барилгын бодит үнэ цэнийг тодорхойлох зорилгоор хараат бус үнэлгээчнээр дахин үнэлүүлсэн. Барилгын дахин үнэлгээг хийхдээ өртөг болон зах зээлийн үнэлгээний хандлагыг хослуулан ашигласан.

Удирдлага барилгын бодит үнэ цэнийн үнэлгээг тодорхойлоход хэрэглэсэн төсөөлөл болон үнэлэмж зохистой буюу тохиромжтой гэдэгт итгэж байна.

2.4 Бараа материал

Бараа материалыг анх өртгөөр нь бүртгэдэг. Дараа нь бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тайлагнадаг. Бараа материалын өртгийг сарын жигнэсэн дундаж өртгийн аргаар тооцоолдог. Цэвэр боломжит үнэ цэнэ гэдэг нь хэвийн бизнесийн нөхцөлд бараа материалын тооцоолсон худалдан борлуулах үнээс түүнийг үйлдвэрлэх болон худалдан борлуулахад нэмж гарахаар тооцсон зардлыг хассан дүн юм.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.4 Бараа материал (үргэлжлэл)

Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ нь ертөөсөө доогуур байвал, Компани бараа материалын үнийн бууралтын хасагдуулга байгуулах ба ашиг алдагдалд зардлаар бүртгэдэг. Цэвэр боломжит үнэ цэнийн өсөлтөөс үүссэн бараа материалын хасагдуулгын буцаалтыг, буцаалт гарсан тайлант хугацаанд нь ашиг алдагдалд зардлын бууралтаар хүлээн зөвшөөрнө.

Бараа материал зарагдсан үед, тайлант хугацаанд холбоотой орлогыг хүлээн зөвшөөрөх ба бараа материалын өртгийн дүнг зардлаар хүлээн зөвшөөрнө.

2.5 Урьдчилгаа төлбөр

Урьдчилгаа төлбөр нь мөнгөн хэлбэрээр төлөгдсөн боловч зардал нь гарч амжаагүй төлбөрийг хэлнэ. Урьдчилгаа төлбөрийг анх хөрөнгөөр бүртгэх ба төлөгдсөн мөнгөн дүнгээр нь хэмжинэ. Уг төлбөрийг ашигласны дараагаар эсвэл барагдсан тохиолдолд ашиг эсвэл алдагдал руу тусгадаг.

Урьдчилгаа төлбөртэй холбоотой бүтээгдэхүүний өртөг эсвэл үйлчилгээ нь нэг жилийн дотор зарлагдах бол урьдчилгаа төлбөрийг санхүүгийн байдлын тайланд эргэлтийн хөрөнгөөр ангилна. Бусад тохиолдолд эргэлтийн бус хөрөнгөөр ангилна.

2.6 Үндсэн хөрөнгө

Компани газрын эрхийг санхүүгийн түрээсээрх хөрөнгөөр бүртгэдэг. Монгол улсын Газрын тухай хууль гарахаас өмнө олж эзэмшсэн газрын эрх нь ерөнхийдөө тэг үнэтэй байдаг ба уг хууль 2003 оны 1 сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн. Монгол улсын Газрын тухай хууль нь Монгол улсын аж ахуйн нэгжүүдэд газрын эрх эзэмшиж эрхзүйн үндсийг тогтоосон.

Газрын эрхийг хувь хүн болон бусад аж ахуйн нэгжүүдээс худалдан авсан бол худалдан авсан өдрөөрх зах зээлийн үнээр бүртгэсэн. Компани газрын эрх эзэмшиж буй бол Засгийн газарт их хэмжээний бус газрын төлбөр төлдөг.

Түрээслэсэн газрыг үнэ цэнийн бууралтыг хассан өртгөөр илэрхийлдэг. Түрээслэсэн газарт элэгдэл байгуулдаггүй.

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн өртөг дараах зардлуудаас бүрдэнэ. Үүнд:

- Хөнгөлөлт урамшууллын дараах худалдан авсан үнэ, гаалийн татвар болон худалдан авалттай холбоотой буцаан олгогдохгүй татвар
- Удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцлийг хангахтай холбоотой гарсан аливаа шууд зардлууд

Компанийн нэг ба түүнээс дээш жил ашиглана гэж тооцож байгаа томоохон эд анги болон нөөцөлж буй тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгө гэж үзнэ. Үүнтэй төстэйгээр хэрэв эд анги, нөөцөлж буй тоног төхөөрөмжийг зөвхөн үндсэн хөрөнгөтэй холбоотой ашигладаг бол тэдгээрийг мөн үндсэн хөрөнгө гэж бүртгэнэ.

Худалдаж авсан программ хангамж нь холбогдох тоног төхөөрөмжийн үйл ажиллагаатай салшгүй холбоотой бол тухайн тоног төхөөрөмжийн нэг хэсэг байдлаар капиталжуулна.

Тайлант үеийн эцэст өртгөөр илэрхийлэгдсэн үндсэн хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнэ бууралтыг хассан дүнгээр хэмжсэн.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.6 Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

Дахин үнэлсэн дүнгээр илэрхийлэгдсэн үндсэн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд тэдгээрийн дахин үнэлсэн дүнгээр тайлагнах ба хараат бус мэргэжлийн хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээчний зах зээлийн бодит нотолгоонд үндэслэн дахин үнэлсэн өдрийн үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнээс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнэ бууралтыг хассан дүнгээр хэмждэг. Дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх үүднээс тайлагналын үеийн эцэс бүрт хөрөнгийн бодит цэнийг тодорхойлдог.

Дахин үнэлсэн хөрөнгийн дахин үнэлгээнээс үүссэн тухайн жилийн үнийн өсөлтийг иж бүрэн орлогын хэсэгт тусгадаг ба өмчийн хэсэгт хуримтлуулан бүртгэдэг. Харин өмнөх жилийн үнэлгээгээр үнийн бууралттай гарсан хөрөнгийн хувьд дахин үнэлгээгээр нэмэгдсэн дүнг өмнөх бууралтын дүнг нөхөх хэмжээгээр тухайн жилийн ашгаар тусгадаг. Дахин үнэлгээгээр хөрөнгийн дансны үнийг бууруулах тохиолдолд эхлээд тухайн хөрөнгийн өмнөх жилийн үнэлгээнээс үүссэн дахин үнэлгээний нөөцийг бууруулах ба илүү гарсан хэсгийг тухайн жилийн алдагдлаар тусгадаг.

Дахин үнэлсэн үндсэн хөрөнгийн элэгдлийг тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг. Дахин үнэлсэн хөрөнгийг худалдах эсвэл ашиглалтаас хасах үед дахин үнэлгээний санд үлдсэн нэмэгдлийг хуримтлагдсан ашиг руу шууд шилжүүлнэ.

Үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан дараа үеийн зардал нь тухайн хөрөнгийн анх тооцсон бүтээмжийн түвшинг нэмэгдүүлэх замаар Компанид эдийн засгийн ирээдүйн өгөөжийг авчрах магадлалтай үед зардлын дүнгээр хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлдэг. Бусад бүх худалдан авалтын дараа гарсан зардлуудыг гарсан тайлант үед нь зардлаар бүртгэнэ.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар, дараах тооцоолсон элэгдлийн жилээр тооцоолсон. Үүнд:

Түрээслэсэн газар	0 жил
Барилга байгууламж	40 жил
Тоног төхөөрөмж	10 жил
Тавилга, эд хогшил	10 жил
Тээрийн хэрэгсэл	10 жил

Тооцоолсон ашиглалтын жил, үлдэх өртөг болон элэгдлийг бодох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг. Санхүүгийн түрээсээр худалдан авсан үндсэн хөрөнгийг бусад үндсэн хөрөнгийн адил тэдгээрийн тооцоолсон ашиглалтын жилээр нь элэгдүүлдэг ба бусад тохиолдолд тухайн үндсэн хөрөнгийг тухайн хөрөнгийн ашиглалтын жил ба түрээсийн хугацааны аль багаар нь элэгдүүлнэ.

Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл үндсэн хөрөнгийн зүйлийг бүртгэлээс хасдаг. Үндсэн хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг алдагдалд тусгана.

Дахин үнэлсэн хөрөнгийг борлуулах эсвэл данснаас хасах үед тухайн хөрөнгөд ногдох дахин үнэлгээний нөөцийг шууд хуримтлагдсан ашиг руу ангилна.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.7 Биет хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант үеийн эцэст биет хөрөнгийн дансны үнийг үнэ цэнэ бууралтын шинж тэмдэг илэрсэн эсэхийг тодорхойлох шалгалтанд хамруулдаг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол үнэ цэнэ бууралтын алдагдал (ийм алдагдал гарсан бол)-ыг тогтоохын тулд тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно. Хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тухайн хөрөнгийн хувьд тооцоолох боломжгүй бол уг хөрөнгийн харьяалагдах "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн нөхөгдөх боломжтой үнийг тооцоолно. "Мөнгөн орлого үүсгэгч нэгж"-д хуваарилах боломжийн бөгөөд тууштай суурь үзүүлэлтийг тодорхойлж чадвал аж ахуйн зориулалттай хөрөнгийг тодорхой "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-д хуваарилах ба ийм боломжгүй бол хамгийн боломжийн бөгөөд тууштай ашиглах боломжтой суурь үзүүлэлтийг ашиглан хамгийн жижиг "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-д хамааруулан шалгадаг.

Хөрөнгийн эсвэл "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн нөхөгдөх боломжтой үнэ гэдэг нь хөрөнгийн бодит үнээс борлуулах өртөг зардлыг хассан цэвэр дүн ба хөрөнгийг ашигласнаар олж болох өгөөж хоёрын аль ихээр нь тогтоогдоно. Ашигласнаар олж болох өгөөжийг үнэлэхдээ татварын өмнөх дискаунтын хувиар дискаунтлан тооцсон ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг ашигладаг. Дискаунтын хувь нь мөнгөнийн цаг хугацааны үнэ цэнэ болон тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдлийн одоогийн зах зээлийн үнэлэмжийг тусгасан байх ёстой. Үнэ цэнэ бууралтын шалгалтын зорилгоор дангаар нь шалгах боломжгүй хөрөнгийг цаашид ашигласнаар бусад хөрөнгө эсвэл бүлэг хөрөнгөөс ("мөнгөн орлого үүсгэгч нэгж") хамааралгүйгээр дангаараа мөнгөн орлого бий болгох чадвартай хамгийн жижиг хөрөнгийн бүлэгт хамааруулан шалгадаг.

Нэгж хөрөнгө эсвэл түүний харьяалагдах "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн дансны үнэ нь нөхөгдөх боломжтой тооцоолсон үнээс их байвал үнэ цэнэ бууралтын алдагдлыг бүртгэж, иж бүрэн орлогын тайланд тусгана.

Өмнөх жилүүдэд бүртгэсэн үнэ цэнэ бууралтын алдагдал буурсан эсвэл алдагдал үгүй болсон эсэхийг илрүүлэхийн тулд үнэ цэнэ бууралтын алдагдлыг тайлангийн өдрөөр дахин хянана. Нөхөгдөх боломжтой дүнг тодорхойлоход хэрэглэсэн тооцоолол өөрчлөгдсөн бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана. Үнэ цэнийн бууралт бүртгээгүй байсан бол байх байсан эцэгдэл хорогдлыг хассан хөрөнгийн дансны үнийг бууруулахгүй байхаар бодож үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана.

2.8 Санхүүгийн хэрэгслүүд

Компани тухайн хэрэгслийн гэрээний нэг оролцогч тал болсон үед санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өрийг санхүүгийн байдлын тайланд тусгадаг.

Санхүүгийн хөрөнгө ба ер төлбөрийг анх үүсэх үеийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Санхүүгийн хэрэгсэл (бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслээс бусад)-ийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг анх бүртгэлд тусгахдаа санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ дээр нэмж эсвэл ба ер төлбөрийн бодит үнэ цэнээс хэсч бүртгэнэ. Бодит үнэ цэнээр бүртгэж өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг шууд тухайн жилийн ашиг алдагдлаар бүртгэнэ.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.9 Санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгийн хэрэгслийг дараах байдлаар ангилдаг. Үүнд: бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хэрэгсэл, гэрээний хугацаа дуустал эзэмших хэрэгсэл, арилжаалах боломжтой хэрэгсэл ба зээл ба авлага болно. Энэхүү ангилал нь тухайн санхүүгийн хөрөнгийн мөн чанар болон тэдгээрийг ямар зориулалтаар эзэмшиж байгаагаас хамаарах ба анх бүртгэхдээ ангиллыг тогтоодог. Ердийн журмаар худалдах, худалдан авах санхүүгийн хөрөнгийг бодит гүйлгээ гарсан өдрөөр нягтлан бодох бүртгэлд тусгах эсвэл бүртгэлээс хасдаг. Ердийн журмаар худалдах, худалдан авах гэдэг нь тогтоосон хугацааны дотор эсвэл тухайн зах зээл дээр тогтсон дүрэм журмаар хөрөнгийг шилжүүлэх нөхцлөөр санхүүгийн хөрөнгийг худалцах, худалдан авахыг хэлнэ.

Компанийн санхүүгийн хөрөнгө нь зээл ба авлагаас бүрдэж байна.

2.9.1 Зээл ба авлага

Зээл ба авлага нь идэвхитэй зах зээл дээр арилжаалагддаггүй бөгөөд тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөрийн хуваарьтай үүсмэл бус санхүүгийн хөрөнгө юм. Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа зээл ба авлага (үүнд дансны ба бусад авлагууд, касс болон харилцах дансан дахь мөнгөн хөрөнгө багтана) нь үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хэмжигдэж, тухайн тайлангийн өдрөөс хойш 12 сараас хугацаанд төлөгдөх хугацаагайгаас бусад тохиолдолд эргэлтийн хөрөнгөөр тайлагнагдана.

Бодит хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өрийн хорогдуулсан өртгийг бодох ба хүү тооцох хугацааны турш бүртгэх хүүгийн зардлыг хуваарилах арга юм. Бодит хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөрийг санхүүгийн өрийн гэрээний хугацааны эцэс гэхэд анх бүртгэсэн цэвэр дансны үнэтэй яг тэнцүү байхаар төлбөрийг өрийн хугацаа эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хуваарилахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

Хүүгийн орлогыг бодит хүүгийн аргаар тооцож бүртгэдэг боловч хүүгийн орлого нь материаллаг бус богино хугацааны авлагад нэрлэсэн хүүгийн хувиар орлогыг бүртгэдэг.

2.9.2 Санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасах

Компани нь санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн гүйлгээг авах гэрээний эрхийн хугацаа дууссан, эсвэл санхүүгийн хөрөнгө шилжүүлсэн, хөрөнгийг эзэмшихтэй холбоотой ихэнх эрсдэл ба өгөөжийг бусдад шилжүүлсэн бол санхүүгийн хөрөнгийг данснаас хасна. Хэрвээ Компани нь санхүүгийн хөрөнгийг шилжүүлээгүй боловч санхүүгийн хөрөнгийг эзэмшихтэй холбоотой ихэнх эрсдэл ба өгөөжийг хадгалж үлдээгүй бол уг хөрөнгөөс Компанид үлдсэн хувь хэмжээгээр хөрөнгийг бүртгэлдээ хэвээрээ үлдээх ба төлбөр төлөх үүрэг байгаа бол холбогдох өрийг бүртгэнэ. Хэрвээ Компани нь шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийн ихэнхийг өөртөө хадгалсаар байгаа бол санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасахгүй ба санхүүгийн хөрөнгөөр барьцаалсан зээлийн өрийг бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь данснаас хасахаас бусад үед (жишээ нь Компани шилжүүлсэн хөрөнгийнхөө зарим хэсгийг буцаан худалдаж авах сонголт байгаа үед) Компани санхүүгийн хөрөнгийн дансны үнийг цаашдын оролцоо нь хэвээр хадгалагдах хэсэг болон цаашид хүлээн зөвшөөрөх боломжгүй хэсгүүдэд санхүүгийн хэрэгслийг шилжүүлэх өдрийн хэсэг тус бүрийн бодит үнэ цэнэд үндэслэн хуваарилна. Бүртгэлээс хассан хэсэгт хуваарилагдсан дансны үнээс түүний төлбөрт хүлээн авсан мөнгө ба бүртгэлээс хассан хэсэгтэй холбоотойгоор бусад иж бүрэн орлогоор тусгасан нийт өлз гарзын нийлбэрийг хасаад гарсан зөрүүг ашиг алдагдалд тусгана. Бусад иж бүрэн орлогоор тусгасан нийт өлз гарзыг бүртгэлд үлдээх хэсэг болон бүртгэлээс хасах хэсэгт тухайн хэсгүүдийн бодит үнэ цэнэд үндэслэн хуваарилна.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.9 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

2.9.3 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоонд:

- үнэт цаас гаргагч буюу харилцагч тал ихээхэн санхүүгийн хүндрэлтэй болох;
- гэрээний үүргээ биелүүлэхгүй байх, тухайлбал хүү ба үндсэн төлбөрийн хугацааг хөтрүүлэх, төлж чадахгүй болох
- зээлдэгч нь дампуурлаа зарлах эсвэл санхүүгийн хувьд дахин бүтцийн өөрчлөлт хийх магадлалтай болсон; эсвэл
- санхүүгийн хүндрэлийн улмаас тухайн санхүүгийн хөрөнгийн идэвхитэй зах зээл үгүй болсон гэх зэрэг орно.

Дансны авлага тэх мат зарим санхүүгийн хөрөнгө нь дангаараа үнэ цэнийн бууралтанд өртөөгүй гэж үзсэн ч нийт багцын хувьд үнэ цэнийн бууралт явагдсан эсэхийг шалгана. Компанийн авлагаа цуглуулдаг туршлага, 30 хоногийн дундаж зээлийн хоногоос хугацаа хэтэрсэн авлагын тоо нийт авлагын багцад өссөн, мөн авлага төлөгдөхгүй, төлбөрийн чадваргүй болж байгаа нь улсын болон орон нутгийн эдийн засгийн нөхцөл байдал мэдэгдэхүйц өөрчлөлттэй холбоотой байвал авлагын багцын үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо гэж үздэг.

Хорогдуулсан өртгөөр хэмжигддэг санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг тухайн хөрөнгийн анх олж бэлтгэх үеийн хүүгийн хувиар дискаунтласан ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлно.

Өртгөөр хэмжигддэг санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг ижил төстэй хөрөнгийн одоогийн зах зээлийн хүүгийн хувиар дискаунтласан ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлно. Ийм үнэ цэнийн бууралтын алдагдлыг хожим нь буцааж бүртгэдэггүй.

Авлагаас бусад санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг тухайн хөрөнгийн дансны үнийг бууруулж бүртгэнэ. Худалдааны авлагын хувьд эргэлзээтэй авлагын сангийн дансаар дамжуулж үнэ цэнэ бууралтын алдагдлыг бүртгэдэг. Авлагыг цуглуулах найдваргүй гэж үзвэл авлагыг эргэлзээтэй авлагын сан руу хааж данснаас хасдаг. Данснаас хассан авлага нь хожим нь төлөгдвөл эргэлзээтэй авлагын санд бичсэн бичилтийг буцаана. Эргэлзээтэй авлагын сангийн дансны үлдэгдлийн өөрчлөлтийг ашиг алдагдалд тусгана.

Хорогдуулсан өртгөөр хэмжигддэг санхүүгийн хөрөнгийн хувьд дараачийн санхүүгийн жилд үнэ цэнийн бууралтын алдагдал буурсан ба ийнхүү буурсан нь үнэ цэнийн алдагдлыг бүртгэсний дараа бий болсон үйл явдалтай холбоотой гэдэг нь бодитойгоор нотлогдож байвал өмнө бүртгэсэн үнэ цэнэ бууралтын алдагдлыг буцаана. Ингэхдээ үнэ цэнийн бууралт бүртгээгүй байсан бол байх байсан хөрөнгийн хорогдуулсан өртгийг бууруулахгүй байхаар бодож үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана.

Санхүүгийн хэрэглүүрийг цэвэр дүнгээр тайлагнах

Цэвэр дүнгээр нь хүлээн зөвшөөрч болохуйц хууль ёсны эрх үүссэн мөн цэвэр дүнгээр нь талж барагдуулах зорилготой эсвэл нэгэн зэрэг хөрөнгө бүртгэж, өр төлөх бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг хааж цэвэр дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд тусгадаг.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.10 Санхүүгийн өрийн ба өмчийн хэрэгсэл

2.10.1 Өр эсвэл өмчийн хэрэгслээр ангилах

Компаниас гаргаж байгаа өрийн болон өмчийн хэрэгслийг тэдгээрийн гэрээнд тусгагдсанвар ямар нөхцөл, бодит байдал үүссэн бөгөөд санхүүгийн өр эсвэл өмчийн хэрэгслийн тодорхойлолтод нийцэж байгаа эсэхийг үндэслэн өр эсвэл өмчийн хэрэгсэл гэж ангилдаг.

2.10.2 Өмчийн хэрэгсэл

Компанийн бүх хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хэсгээс хувь хүртэх нөхцөл бүхий аливаа гэрээг өмчийн хэрэгсэл гэдэг. Компаниас гаргаж байгаа өмчийн хэрэгслийг хүлээн авсан мөнгөнөөс санхүүгийн хэрэгслийг гаргахтай холбоотой шууд зардлыг хассан дүнгээр хэмжиж бүртгэдэг.

2.10.3 Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг нь зарласан ногдол ашиг хуваарилсны дараах Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуримтлагдсан ашиг юм. Мөн хуримтлагдсан ашигт холбогдох стандартуудаар шаарддаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой нөлөөллийг оруулж болно. Харин хуримтлагдсан алдагдал нь компанийн өнөөг хүртэлх хуримтлагдсан алдаглыг харуулна.

2.10.4 Санхүүгийн өр төлбөр

Анхдагч хүлээн зөвшөөрөлт

Компани тухайн хэрэгслийн гэрээний нэг оролцогч тал болсон үед санхүүгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгадаг. Санхүүгийн өр төлбөрийг анх үүсэх үеийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг өрийн хэрэгслээс бусад санхүүгийн өр төлбөрийг гаргахтай холбоотой гарсан ажил гүйлгээний өртгийг тухайн өр төлбөрийн анхны өртөгт оруулж бүртгэдэг.

Санхүүгийн өр төлбөрийг "бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг" өрийн хэрэгсэл эсвэл бусад санхүүгийн өр төлбөр гэж хоёр ангилдаг. Компанийн санхүүгийн өр төлбөр нь зөвхөн бусад санхүүгийн өр төлбөрөөс бүрдэнэ.

2.10.5 Санхүүгийн бусад өр төлбөр

Бусад санхүүгийн өрийг (үүнд эзэлийн өр болон дансны ба бусад өглөг багтана) бодит хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр хэмжиж бүртгэнэ. Бодит хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өрийн хорогдуулсан өртгийг бодох ба хүү тооцох хугацааны турш бүртгэх хүүгийн зардлыг хуваарилах арга юм. Бодит хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр (бодит хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан)- ийг санхүүгийн өрийн гэрээний хугацааны эцэс гэхэд анх бүртгэсэн цэвэр дансны үнэтэй яг тэнцүү байхаар төлбөрийг өрийн хугацаа эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хуваарилахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

2.10.6 Санхүүгийн өрийг бүртгэлээс хасах

Компани нь санхүүгийн өр төлбөрийг зөвхөн гэрээний үүрэг биелэгдсэн, цуцлагдсан эсвэл гэрээний хугацаа дууссан тохиолдолд бүртгэлээс хасна. Бүртгэлээс хасч буй санхүүгийн өрийн дансны үнэ ба түүний оронд хүлээн авсан ба авах хэрэгслийн хооронд үнийн зөрүү байвал ашиг алдагдлаар бүртгэнэ.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын зураангуй (үргэлжлэл)

2.11 Орлого хүлээн зөвшөөрөлт

Орлогыг харилцагчаас хүлээн авсан болон хүлээн авах зүйлийн бодит үнэ цэнээр хэмждэг. Орлогыг тооцоолж буй борлуулалтын буцаалт, худалдааны хөнгөлөлт, эдгээртэй ижил төстэй хөнгөлөлтүүдийг хассан цэвэр дүнгээр бүртгэдэг.

2.11.1 Борлуулсан бараа, бүтээгдэхүүн

Хэвийн бизнесийн нөхцөлд бараа, бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг борлуулалтын буцаалт, худалдааны хөнгөлөлтийг хассаны дараах хүлээн авсан эсвэл хүлээн авах авлагын бодит үнэ цэнээр хэмжинэ. Дараах бүх нөхцөл бүрдсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Барааг эзэмших өмчлөхтэй холбоотой эрсдэл ба өгөөж нь худалдан авагчид шилжсэн;
- Борлуулсан барааныхаа өмчлөлд холбогдох удирдлагын болон хяналтын үүргийг өөртөө хадгалаагүй;
- Орлогыг найдвартайгаар хэмжих боломжтой;
- Ажил гүйлгээний эдийн засгийн өгөөжийг Компани хүртэх магадлалтай;
- Тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан болон гарах зардлуудыг найдвартайгаар хэмжиж, тодорхойлох боломжтой;

Ялангуяа, барааг худалдан авагчид хүргэсэн мөн хууль ёсны өмчлөл нь худалдан авагчид шилжсэн үед бараа, бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрдөг.

Хэрвээ хөнгөлөлт үзүүлэх нь магадлалтай мөн дүнг нь найдвартайгаар хэмжих боломжтой бол орлогыг хүлээн зөвшөөрөхдөө уг хөнгөлөлтийг орлогоос хасч бүртгэнэ.

2.11.2 Хүүгийн орлого

Эдийн засгийн өгөөж нь Компанид ирэх өндөр магадлалтай ба орлогын дүнг найдвартайгаар тооцоолох боломжтой тохиолдолд хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрнө. Хүүг хугацаанаас хамааралтайгаар үндсэн өрийг бодит хүүгийн хувиар үржүүлж хуримтлуулан бүртгэдэг. Бодит хүүгийн хувь гэдэг нь санхүүгийн өрийн хорогдуулсан өртгийг бодох ба хүү тооцох хугацааны турш бүртгэх хүүгийн зардлыг хуваарилах арга юм. Бодит хүүгийн хувь нь ирээдүйд хүлээн авахаар тооцоолсон бүх мөнгөн төлбөрийг тухайн санхүүгийн хэрэгслийн гэрээний хугацааны туршид хуваарилахад хугацааны эцэс гэхэд анх бүртгэсэн цэвэр дансны үнэтэй яг тэнцүү дүн үлдсэн байхаар дискаунталдаг хүүгийн хувь юм.

2.11.3 Үйлчилгээний орлого

Үйлчилгээний орлогыг үйлчилгээ үзүүлсний дараа хөнгөлөлт болон хасагдуулгыг хассан дүнгээр хүлээн зөвшөөрнө.

2.11.4 Түрээсийн орлого

Үйл ажиллагааны түрээсийн орлогыг нийт түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар тооцож ашиг алдагдлын тайланд тусгадаг

2.11.5 Бусад орлого

Бусад орлого нь бизнесийн хэвийн бус нөхцөлд үүссэн бөгөөд эдийн засгийн өгөөжийг найдвартай хэмжих боломжтой, үүнийг Компани хүртэх магадлалтай үед бусад орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.12 Түрээс

Хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл болон урамшууллыг түрээслэгчид шилжүүлж байвал уг түрээсийг санхүүгийн түрээсээр тайлагнадаг. Бусад бүх түрээсийг үйл ажиллагааны түрээсээр тайлагнадаг.

2.12.1 Түрээслүүлэгч

Үйл ажиллагааны түрээсийн орлогыг түрээсийн нийт төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын арга ашиглан бүртгэдэг. Түрээсийн гэрээ байгуулах үед гарсан нэмэлт зардлуудыг түрээсийн хөрөнгө оруулалт дээр нэмж бүртгэж, түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар хорогдуулдаг.

2.12.2 Түрээслэгч

Үйл ажиллагааны түрээсийн нийт төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын арга ашиглан зардлаар бүртгэдэг. Үйл ажиллагааны түрээстэй холбоотой болзошгүй төлбөрийг гэдгээрийг гарсан жилд зардлаар бүртгэдэг. Үйл ажиллагааны түрээсийн гэрээний дагуу урамшуулал авсан бол түүнийг өр төлбөр гэж бүртгэдэг ба түрээсийн хугацаанд шулуун шугамын арга ашиглан түрээсийн өглөгийг бууруулж, зардлаар бүртгэдэг.

2.13 Гадаад валютын ажил гүйлгээ

Төгрөгөөс бусад мөнгөн тэмдэгт нь гадаад валют гэж тооцогддог ба гадаад валютаар хийгдсэн гүйлгээнүүд нь тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар төгрөг рүү хөрвүүлэгддэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөр нь тухайн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар төгрөг рүү хөрвүүлэгддэг. Энэхүү гадаад валютын хөрвүүлгийн гүйлгээнээс үүссэн ханшийн зөрүүг тухайн тайлант хугацаанд иж бүрэн орлогын тайлангийн хэсэгт тусгадаг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн хөрөнгө ба өр төлбөр нь тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар хөрвүүлэгддэг. Мөнгөн зүйлсийн хөрөнгө ба өр төлбөрийн дахин хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүгийн олз, гарзыг тухайн жилийн ашиг алдагдлаар бүртгэх ба мөнгөн бус зүйлсийн хөрөнгө болон өр төлбөрийн хөрвүүлэлттэй холбоотой үүссэн гадаад валютын ханшийн өөрчлөлтийг шууд эздийн өмчийн хэсэгт тусгана. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн хөрөнгө ба өр төлбөр нь түүхэн ханшаараа хэмжигдэх бөгөөд дахин хөрвүүлэлт хийдэггүй.

Санхүүгийн тайлангийн өдрөөрх гол нөлөө үзүүлэхүйц гадаадын мөнгөн тэмдэгтийн валютын ханш нь дараах байдлаар илэрхийлэгдэж байна:

	2015	2014
АНУ-ын доллар	1,995.98	1,885.60
Японы иен	16.58	15.74
БНХАУ-ын юань	307.54	303.57

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.14 Зардал хүлээн зөвшөөрөлт

Хөрөнгийг бууруулах эсвэл өр төлбөрийг нэмэгдүүлэх байдлаар ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буурах ба түүнийг бодитой хэмжих боломжтой үед зардлыг ашиг, алдагдлаар бүртгэнэ. Зардлыг ашиг алдагдлаар бүртгэхдээ тухайн зардал гарснаар олсон орлоготой уялдуулж бүртгэх, хэрэв эдийн засгийн өгөөж нь хэд хэдэн тайлангийн хугацаа дамнан орж ирэхээр бол түүнчлэн зардал ба орлогын уялдаа холбоо шууд тодорхойлогдохгүй, өргөн цар хүрээгээр холбогдож байвал зардлыг системтэй ба зүй зохистой аргаар хуваарилж бүртгэх, хэрэв зардал нь ирээдүйн өгөөжийг бий болгоогүй, эсвэл ирээдүйн эдийн засгийн өгөөж нь санхүүгийн байдлын тайлан дээр хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй эсвэл хангаж чадахгүй болсон үед зардлыг шууд хүлээн зөвшөөрч тус тус бүртгэдэг.

Зардлыг иж бүрэн орлогын тайланд зардлын чиг үүргийн аргыг ашиглан тайлагнадаг. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт борлуулсан барааны бүтээгдэхүүнтэй шууд холбоотой зардлууд багтдаг. Харин үйл ажиллагааны зардалд ерөнхий ба удирдлагын, борлуулалт, маркетингийн болон Компанийн бусад бизнесийн үйл ажиллагааны зардлууд ордог.

2.15 Зээлийн зардал

Шалгуурт нийцсэн хөрөнгийн олж бэлтгэх, барьж байгуулах ба үйлдвэрлэхэд шууд холбоотой хүүгийн зардлыг тэдгээр хөрөнгийн өртөгт оруулж бүртгэдэг. Шалгуурт нийцсэн хөрөнгө гэдэг нь түүнийг зориулалтаар нь ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгоход их хэмжээний хугацаа зарцуулдаг хөрөнгийг хэлэх ба уг хөрөнгийг ашиглах ба борлуулахад бэлэн болгох хүртэлх хугацаанд хүүгийн зардлыг хөрөнгийн өртөгт оруулдаг.

Шалгуурт нийцсэн хөрөнгийг санхүүжүүлэхээр хүлээж буй зээлийг сул чөлөөтэй үед нь богино хугацаагаар хүү олох хөрөнгө оруулалтанд ашигласан бол олсон хүүг капиталжуулах хүүгийн зардлыг бууруулж бүртгэнэ.

Бусад бүх зээлийн хүүг тэдгээрийг гарсан жилийн ашиг алдагдлын тайланд тусгана.

2.16 Ажилчдын тэтгэмж

2.16.1 Богино хугацаат тэтгэвэр тэтгэмж

Компани нь тайлант хугацаанд ажилчдад олгох цалингийн зардлаас төлсөн төлбөрийг хаасан цавар дүнгээр өрийг бүртгэдэг. Түүнчлэн Компани нь ойрын хугацаанд мөнгөн шагнал олгох, ашиг хуваах хөтөлбөрийн хүрээнд төлөх дүнгээр өр бүртгэдэг. Ингэхдээ Компани нь ажилчдынхаа үзүүлсэн өнгөрсөн үеийн үйлчилгээний үр дүнд нийхүү төлөхөөр хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хүлээсэн бөгөөд холбогдох өрийн дүнг найдвартайгаар тооцоолох боломжтой бол өрийн санг бүртгэдэг. Богино хугацаат тэтгэвэр, тэтгэмжийг ажилчид үйлчилгээ үзүүлсэн үед дискаунтлаагүй сууриар хэмжиж, зардлаар хүлээн зөвшөөрдөг.

2.16.2 Ажлаас гарсны дараах тэтгэвэр тэтгэмж

Компани нь улсын нийгмийн даатгалын системийн хүрээнд ажилчдын цалин болон тэтгэмжийн нийт дүнгээс тодорхой хувиар тооцон ногдуулдаг тухайн жилийн нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрөөс өөр тэтгэвэр тэтгэмжийн гэрээ хэлцэлгүй болно. Энэхүү шимтгэл нь тодорхой тэтгэвэр, тэтгэмжийн даатгалд төлсөн шимтгэлийн төлбөрийг ажилчид ажил үүргээ гүйцэтгэж энэхүү шимтгэлийг олох эрх авсан хугацааны зардлаар бүртгэдэг. Компани нь үүнээс өөр тэтгэвэрт гарсны дараах тэтгэвэр тэтгэмжийн болон хуримтлуулан тооцох шаардлагатай их хэмжээний тэтгэмжийн өр төлбөргүй болно.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.17 Нөөц

Компани нь өнгөрсөн үйл явдлын улмаас хуулиар үүрэг хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн бөгөөд энэхүү үүргийг барагдуулахад эдийн засгийн өгөөжийг зарцуулах өндөр магадлалтай бөгөөд үүрэг хариуцлагыг бодитоор хэмжих боломжтой бол нөөцийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Бүртгэлд тусгагдсан нөөцийн дүн нь үүссэн өрийг төлж барагдуулахад шаардагдах мөнгөн дүнгийн хэмжээг тайлант жилийн эцсийн байдлаар тухайн өртэй холбоотой нөхцөл байдал, эрсдэлийг харгалзан тооцоолсон удирдлагын хийж чадах хамгийн сайн тооцоололд үндэслэдэг.

Одоогийн үүссэн өрийг барагдуулахад хэрэгтэй тооцоолж буй мөнгөн гүйлгээнд үндэслэн нөөцийг хэмждэг ба түүний дансны дүн нь тэдгээр мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр тодорхойлогддог.

Нөөцийг барагдуулахад шаардлагатай эдийн засгийн өгөөжийг бүгдийг нь эсвэл заримыг нь гуравдагч тал нөхөн төлөх магадлалтай ба хэрэв нөхөн төлөх нь тодорхой болсон бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг найдвартай хэмжих боломжтой үед түүнийг авлага хэмээн бүртгэнэ. Нөөцийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин хянах ба тайлант хугацааны эцэст хамгийн сайн тооцооллыг тусгаж залруулдаг. Эдийн засгийн өгөөжийг шилжүүлж өр төлбөрийг барагдуулах шаардлагагүй болсон үед нөөцийг буцаана.

2.18 Болзошгүй өр төлбөр ба хөрөнгө

Аж ахуйн нэгжийн бүрэн хяналтаас гадуурх нэг болон түүнээс дээш ирээдүйн үйл явдал тохиолдох, эс тохиолдохоос хамаарч үүсэх эсэх нь тодорхойлогддог тул болзошгүй өр ба болзошгүй хөрөнгийг бүртгэдэггүй. Эдийн засгийн өгөөжийг агуулсан нөөцийн гадагш урсгал гарах магадлал маш бага биш л бол бүх тохиолдолд болзошгүй өр төлбөрийг санхүүгийн тайланд нэмж тодруулна.

Харин эдийн засгийн өгөөж орж ирэх өндөр магадлалтай үед л болзошгүй хөрөнгийг санхүүгийн тайланд нэмж тодруулна.

2.19 Холбоотой талын гүйлгээ

Компани болон Компанийн толгой компани болон түүнтэй холбоотой этгээдүүдийн хооронд нөөц, ажил үйлчилгээ эсвэл үүрэг хариуцлага шилжүүлэхдээ төлбөр нэхэмжилсэн эсэхээс үл хамааран тэдгээрийн хооронд хийгдсэн ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ гэнэ. Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд Компанитай холбоотой гэж үзнэ.

- Компанийг шууд эсвэл хамтран хянадаг
- Компанийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг
- Компанийн болон Компанийн толгой компанийн удирдах ажилтан

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.19 Холбоотой талын гүйлгээ (үргэлжлэл)

Хэрэв дараах нөхцөлийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгжийг Компанитай холбоотой гэж үзнэ:

- нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан бүлгийн нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол,
- Хоёр компани хоёулаа нэг гуравдагч этгээдийн хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол,
- нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан үйлдвэр ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч аж ахуйн нэгжийн хараат компани бол,
- Тухайн аж ахуйн нэгж нь дээр дурьдсан холбоотой талаар тодорхойлогдсон хувь хүний шууд эсвэл хамтарсан хяналтан дор байх,
- Компанийг шууд эсвэл хамтран хянадаг этгээд нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд их хэмжээний нөлөөтэй байх, тухайн аж ахуйн нэгжийн, эсвэл түүний голтой компанийн удирдаж ажилтан,

2.20 Татвар

Орлогын татварын зардал нь тухайн жилд төлөхөөр тооцсон татвар ба хойшлогдсон татварын нийлбэрээс бүрдэнэ.

2.20.1 Тухайн жилийн орлогын албан татвар

Тухайн жилийн татварын өглөг нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод суурилсан байна. Татвар ногдуулах орлого нь Компанийн санхүүгийн тайлангаар тодорхойлоон ашгаас зөрүүтэй байдаг нь санхүүгийн тайланд тусгагдсан орлого, зарлагын зүйлсийн татвар ногдох, татвар ногдох орлогоос хасагдах хугацаа нь татварын тайлангийн зорилгоор өөр тайлант хугацаанд үүсдэг эсвэл эдгээр нь өгт татвар ногдохгүй эсвэл татвар ногдох орлогоос хасагдахгүй байдагтай холбоотой. Компанийн тухайн жилийн татварын өрийг тайлант өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно.

2.20.2 Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлан дахь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар ногдуулах орлогыг тооцоход хэрэглэсэн тэдгээрийн татварын суурь хоёрын хоорондын түр зөрүүнд тооцдог. Ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүгээр хойшлогдсон татварын өрийг бүртгэдэг. Хойшлогдсон татварын хөрөнгийг бараг бүх хасагдах түр зөрүүнд тооцдог боловч ирээдүйд тэдгээр хасагдах түр зөрүүг шингээхэд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх өндөр магадлалтай эсэхийг харгалздаг. Эдгээр хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг гүүдвэл болон татварын ногдуулах орлого ба санхүүгийн ашгийн аль алинд нь нөлөөлдөггүй ажил гүйлгээ (бизнесийн нэгдлээс бусад)-ний үед бусад хөрөнгө бө өр төлбөрийг анх бүртгэхэд үүссэн түр зөрүүгээр бүртгэдэггүй.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэст хянаж үздэг ба уг хөрөнгийг болон хөрөнгийн зарим хэсгийг нөхөхөд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх магадлал бага болсон бол дансны үнийг бууруулдаг.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.20 Татвар (үргэлжлэл)

Тайлант жилийн татварын зардал нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод санхүүгийн байдлын тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээг ашиглан ногдуулсан татварын өр болон өмнөх жилүүдийн татварын өртэй холбоотой залруулгаас бүрдэнэ.

Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг уг татварыг үүсгэж байгаа хөрөнгө, өр төлбөрийг борлуулах, барагдуулах үеийн татварын хувийг ашиглан хэмжих ба тайлант өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно. Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг хэмжихдээ уг татварыг үүсгэж байгаа хөрөнгө, өр төлбөрийг тайлант өдрийн байдлаар Компани хэрхэн борлуулах, барагдуулахаар төлөвлөж байгаа ба түүнээс хамаарсан татварын нөлөөллийг тусгасан байх ёстой.

2.20.3 Тухайн жилийн болон хойшлогдсон татвар

Тухайн жилийн болон хойшлогдсон татварыг тайлант жилийн ашиг алдагдлаар бүртгэх ба харин тэдгээр нь иж бүрэн орлого эсвэл өмчийн хэсэгт шууд бүртгэгдсэн зүйлстэй холбоотой бол харгалзан иж бүрэн орлого эсвэл өмчин хэсэгт бүртгэдэг. Тухайн жилийн болон хойшлогдсон татвар нь бизнесийн нэгдлийг анх бүртгэхтэй холбоотой бол татварын нөлөөллийг бизнесийн нэгдлийн бүртгэлд оруулж тусгана.

2.21 Тайлангийн дараах үйл явдал

Компани санхүүгийн тайлангийн өдөр болон түүнийг хэвлэн нийтлэхийг зөвшөөрсөн өдрийн хооронд гарсан зохистой болон зохисгүй үйл явдлыг тодорхойлдог. Хэрэв жилийн эцсийн санхүүгийн тайланд нөлөөлөхүйц залруулагдах бодитой нотолгоотой үйл явдал бий болсон бол Компанийн санхүүгийн тайланд залруулдаг. Харин үл залруулагдах үйл явдал нь материаллаг нөлөөлөлтэй бол жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тодруулгад тусгадаг.

3. Шинэ болон шинэчлэгдсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС)

3.1 Шинэчлэгдсэн СТОУС-ууд болон шинэ тайлбарууд

Хэрэгжих хугацаа	Шинэ стандартууд болон өөрчлөлтүүд	
2014 оны 7-р сарын 1	СТОУС-ын 2010-2012-ын мөчлөгт хийгдсэн Жилийн шинэчлэлүүд: стандартууд	
	Стандарт	Өөрчлөлтүүдийн агуулга
	СТОУС 2 <i>Хувьцаанд суурилсан төлбөр</i>	Баталгаажих нөхцөл-ийн тодорхойлолт
	СТОУС 3 <i>Бизнесийн нэгдэл</i>	Бизнесийн нэгдэл дэхь болзошгүй нөхцөлүүдийн бүртгэл
	СТОУС 8 <i>Үйл ажиллагааны сегмент</i>	Үйл ажиллагааны сегментүүдийг нэгтгэх эсэхийг шийдвэрлэхэд ашигласан үнэлэмжийн талаар тодруулах
		Тайлагнагч сегментүүдийн нийт хөрөнгийг аж ахуй нэгжийн нийт хөрөнгө рүү тохируулах тохируулга хийхийг шаардсан
	СТОУС 13 <i>Бодит Үнэ Цэнийн Хэмжилт</i>	Богино хугацаат авлага болон өглөг
	НББОУС 16 <i>Үндсэн хөрөнгө</i> НББОУС 38 <i>Биет бус хөрөнгө</i>	Дахин үнэлгээний арга-хуримтлагдсан элэгдэл (хорогдуулалт)-ийг хувь тэнцүүлэн дахин тайлагнах
	НББОУС 24 <i>Холбоотой талуудын тодруулга</i>	Үндсэн удирдлагын албан тушаалтан
	СТОУС-ын 2011-2013-ын мөчлөгт хийгдсэн Жилийн шинэчлэлүүд: стандартууд	
	Стандарт	Өөрчлөлтүүдийн агуулга
	СТОУС 3 <i>Бизнесийн нэгдэл</i>	Хамтарсан үйлдвэрийг стандартын хамрах хүрээнээс хассан
	СТОУС 13 <i>Бодит Үнэ Цэнийн Хэмжилт</i>	Тэмдэглэл 52-ийг хамрах хүрээнд багтаасан (багцын хасалт)
НББОУС 40 <i>Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө</i>	Хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө эсвэл өмчлөгч эзэмшсэн үл хөдлөх хөрөнгө гэж ангилах үеийн СТОУС 13 болон НББОУС 40-ийн уялдаа холбоог тодорхой болгосон	

Дээрхи стандартууд болон тайлбарууд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад онц ач холбогдолтой өөрчлөлтүүдийг бий болгоогүй бөгөөд мөн Компаний санхүүгийн гүйцэтгэл эсвэл санхүүгийн байдалд нөлөөлөөгүй болно.

3. Шинэ болон шинэчлэгдсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС)

3.2 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартууд

Компанийн санхүүгийн тайлангуудыг батлан гаргах үед батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд болон тайлбаруудыг доор тодруулсан болно. Компани эдгээр стандартуудыг хэрэгжих үед тохиромжтой гэж үзвэл дагаж мөрдөх болно.

Хэрэгжих хугацаа	Шинэ стандартууд болон өөрчлөлтүүд
2016 оны 1-р сарын 1	СТОУС 14 Зохицуулалтын шаардлагаар хойшлуулагдах дансдууд
	СТОУС 11-ын өөрчлөлт Хамтарсан үйл ажиллагааны хувь оролцоог олж эзэмших үеийн нягтлан бодох бүртгэл
	НББОУС 16 ба НББОУС 38-ийн өөрчлөлтүүд Элэгдэл ба хорогдлын зохистой аргачлалын ангилал
	НББОУС 1-ийн өөрчлөлт тодруулгын санаачлагууд
	НББОУС 27-ийн өөрчлөлт Тусдаа санхүүгийн тайлан дахь өмчийн арга
	СТОУС 10 ба НББОУС 28-ийн өөрчлөлтүүд Хөрөнгө оруулагч болон түүний хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр* хоорондын хөрөнгийн борлуулалт эсвэл дэмжлэг
	СТОУС 10, СТОУС 12 ба НББОУС 28-ийн өөрчлөлтүүд хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгж: Нэгтгэл гадна хэрэглэх
2018 оны 1-р сарын 1	СТОУС-ын 2012-2014-ын мөчлөгт хийгдсэн Жилийн шинэчлэлүүд
	СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл СТОУС 15 Худалдан авагчтай байгуулсан гэрээнээс орох орлого

*2015 оны 8-р сард НББОУСЗ нь эдгээр өөрчлөлтүүдийн хүчин төгөлдөр болох хугацааны тодорхойгүй хойшлолтонд зориулж стандартын хэлэлцүүлэгт зориулсан хувилбарыг нийтэлсэн ба хугацаанаас өмнө дагаж мөрдөхийг зөвшөөрсөн.

ГОВЬ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2015 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

4. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

	2015	2014
Гадаад валютын харилцах данс болон касс	680,034	353,535
Төгрөгийн харилцах данс болон касс	331,296	882,718
Төгрөгийн богино хугацаатай хадгаламж	17,000,019	15,000,000
	18,011,349	16,236,253

Банкин дахь төгрөгийн харилцах дансанд жилийн 3.6%, америк долларын дансанд жилийн 1.2%-ийн хүү боддог.

Мөнгөтэй адилтгах хөрөнгө нь мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөдөг, үнэ цэнийн өөрчлөлтөд өртөх эрсдэл багатай богино хугацааны өндөр хөрвөх чадвартай бөгөөд дээрх богино хугацаат хадгаламж нь жилийн 6.5 - аас 16.1 хувийн хүүтэй.

5. Дансны ба бусад авлага

	2015	2014
Дансны авлага	5,196,304	4,674,986
Холбоотой талаас авах авлага (Тодруулга 21.1-г үзнэ үү)	7,398,289	54,488
Бусад авлага	128,294	35,975
	12,722,887	4,765,449
Найдваргүй авлагын хасагдуулга	(1,440,549)	(1,431,571)
	11,282,338	3,333,878

5.1. Дансны авлага

Компанийн урьдчилан батлагдсан зээлийн лимитийн дотор зээлийн борлуулалтын төлөгдөх хугацаа дунджаар 90 хоног байна. Хугацаа хэтэрсэн дансны авлагад хүү боддоггүй. Компани нь найдваргүй авлагын хасагдуулгын зардлыг хүлээн зөвшөөрөхдөө авлага тус бүрийн насжилт, тухайн харилцагчийн зээлийн түүх болон харилцагчийн санхүүгийн байдлыг хянаж үздэг.

Компани авлагын төлөгдөх байдлыг тодорхойлохдоо тухайн авлагын анх үүссэнээс хойш санхүүгийн тайлангийн өдөр хүртэлх зээлийн чанарын өөрчлөлтийг авч үздэг. Зээлийн эрсдлийн чанар нь тухайн харилцагчийн том болон холбоогүй байх байдлаар хязгаарлагддаг. Компанийн удирдлага дээрх байгуулсан найдваргүй авлагын хасагдуулга дээр нэмж байгуулах хасагдуулга байхгүй гэж итгэж байна.

Тайлант хугацааны эцсээрх авлага дотор төлөгдөх хугацаа нь хэтэрсэн боловч найдваргүй авлагын хасагдуулгын сан байгуулаагүй (насжилтыг дараах хүснэгтээс харна уу) дараах авлагууд багтсан. Учир нь тэдгээр худалдан авагчийн зээлийн чанарт томоохон өөрчлөлт гараагүй ба авлагыг бүрэн эргэн төлөгдөнө гэж үзэж байна.

Төлөгдөх хугацаа нь хэтэрсэн боловч хэвийн авлагууд

	2015	2014
90 – 180 хоног	479,391	199,773
181 – 360 хоног	355,540	337
361 хоногаос дээш	261,641	27,029
	1,096,572	227,139
Дундаж насжилт (хоногоор)	184	123

ГОВЬ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2015 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

5. Дансны ба бусад авлага (үргэлжлэл)

Найдваргүй авлагын хасагдуулгын хөдөлгөөн:

	2015	2014
Найдваргүй авлагын хасагдуулгын эхний үлдэгдэл	1,431,571	1,960,908
Тайлант жилд байгуулсан хасагдуулга	24,054	-
Сан байгуулсан авлагаас төлөгдсөн	-	(3,096)
Данснаас хассан авлага	(15,076)	(526,241)
Найдваргүй авлагын хасагдуулгын эцсийн үлдэгдэл	1,440,549	1,431,571

5.2. Холбоотой талуудад олгосон зээл болон урьдчилгаа

Богино хугацааны санхүүжилтийн хэрэгцээг хангах зорилгоор холбоотой талуудад зээл олгосон. Холбоотой талуудаас авах авлагын талаар тодруулга 21-ээс харна уу.

6. Урьдчилж төлсөн зардал ба урьдчилгаа төлбөр

	2015	2014
Урьдчилгаа төлбөр	8,522,517	908,901
Урьдчилж төлсөн зардал	55,466	47,225
Урьдчилж төлсөн татвар	14,047	12,707
	8,592,030	968,833

Компани 2015 оны 12 сард барилга худалдан авахаар 7,155 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр төлсөн.

7. Бараа материал

	2015	2014
Түүхий эд материал	20,548,476	14,726,313
Дуусаагүй үйлдвэрлэл	6,661,214	10,936,979
Бэлэн бүтээгдэхүүн	16,443,094	16,510,154
Үйлдвэрлэлийн хангамжийн материал	3,441,382	4,233,143
	47,094,166	46,406,589
Удаан гүйлгээтэй бараа материалын хасагдуулга	(727,383)	(796,097)
	46,366,783	45,610,492

Түүхий эд материалд түүхий ноолуур, самнасан ноолуур болон ноолууран утас багтсан. 2015 онд бараа материалаас борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 43.3 тэрбум төгрөгийг (2014 онд: 39.6 тэрбум) бүртгэсэн. Үйл ажиллагааны зардлаар бүртгэсэн бараа материалын өртөгт удаан гүйлгээтэй болон хуучирсан бараа материалын хасагдуулгын зардал багтсан бөгөөд уг хасагдуулгын хөдөлгөөний шинжилгээг дараах хүснэгтээс харна уу.

Удаан гүйлгээтэй болон хуучирсан бараа материалын хасагдуулгын хөдөлгөөн

	2015	2014
Хасагдуулгын эхний үлдэгдэл	796,097	1,183,042
Тайлант жилд байгуулсан удаан гүйлгээтэй бараа материалын хасагдуулга	194,706	335,016
Өмнө байгуулсан хасагдуулгын нөхөлт	(263,420)	(721,961)
Хасагдуулгын эцсийн үлдэгдэл	727,383	796,097

ГОВЬ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2015 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

8. Үндсэн хөрөнгө

	Түрээслэсэн газар	Барилга, дахин үнэлсэн дүнгээр	Тоног төхөөрөмж өртгөөр	Тавилга эд хөгийл, өртгөөр	Тээврийн хэрэгсэл, өртгөөр	Нийт
Өртөг эсвэл дахин үнэлэгдсэн дүн:						
2013 оны 12-р сарын 31	300,000	13,689,855	33,503,918	1,508,303	976,208	49,978,284
Нэмэгдсэн	-	1,067,802	3,908,750	361,050	339,983	5,677,385
Хасагдсан	-	-	(768,309)	(102,725)	(23,136)	(894,170)
Дахин ангилал	-	137,790	74,794	(212,584)	-	-
2014 оны 12-р сарын 31	300,000	14,895,247	36,719,153	1,554,044	1,293,055	54,761,499
Нэмэгдсэн	-	6,676,922	1,783,492	290,151	204,310	8,954,875
Дахин үнэлгээ	-	4,636,568	-	-	-	4,636,568
Хасагдсан	-	(6,305,300)	(354,851)	(117,394)	(15,011)	(6,792,556)
Дахин ангилал	-	75,764	(4,444)	(71,320)	-	-
2015 оны 12-р сарын 31	300,000	19,979,221	38,143,350	1,655,481	1,482,354	61,560,406
Хуримтлагдсан элэгдэл:						
2013 оны 12-р сарын 31	-	985,668	16,820,581	475,895	338,873	18,621,017
Элэгдлийн зардал	-	351,807	2,909,521	149,330	112,221	3,522,879
Хасагдсан	-	-	(683,426)	(91,685)	(19,083)	(794,194)
Дахин ангилал	-	30,898	8,021	(38,919)	-	-
2014 оны 12-р сарын 31	-	1,368,173	19,054,697	494,621	432,011	21,349,502
Элэгдлийн зардал	-	450,784	3,208,728	203,690	128,674	3,991,876
Дахин үнэлгээ	-	(1,621,172)	-	(18,292)	-	(1,639,464)
Хасагдсан	-	-	(327,880)	(90,552)	(7,846)	(426,278)
Дахин ангилал	-	24,806	(732)	(24,074)	-	-
2015 оны 12-р сарын 31	-	222,591	21,934,813	565,393	552,839	23,275,636
Цэвэр дүн:						
2014 оны 12-р сарын 31	300,000	13,527,074	17,664,456	1,059,423	861,044	33,411,997
2015 оны 12-р сарын 31	300,000	19,756,630	16,208,537	1,090,088	929,515	38,284,770

8.1 Дахин үнэлсэн барилга

Компани 2015 болон 2014 оны 12 сарын 31 нээрх барилгын бодит үнэ цэнийг тодорхойлох зорилгоор хараат бус үнэлгээчнээр барилгыг дахин үнэлүүлсэн. Барилгын дахин үнэлгээг өртөг болон зах зээлийн үнэлгээний хандлагаар үнэлсэн. Барилгыг өртгөөр нь бүртгэж байсан бол барилгын дансны үнэ дараах байдалтай байна.

	2015	2014
Барилга	6,385,651	6,964,266

8.2 Барьцаалсан үндсэн хөрөнгө

2015 болон 2014 оны 12 сарын 31- ний байдлаар харгалзан 18,595 сая төгрөг ба 12,815 сая төгрөгийн дансны үнэтэй барилга ба тоног төхөөрөмжийг банкны зээлэнд барьцаалсан байна. Мөн нэмж газар ашиглах эрхүүдийг банкны зээлэнд барьцаалсан бөгөөд эдгээр газрууд нь барилга худалдан авах үед нийт өртөгт нь шингэсэн учраас түрээслэсэн газруудын үнэлгээг тусад нь тодорхойлох боломжгүй байна (тодруулга 11.1-г харна уу).

ГОВЬ ХК
 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2015 ОН
 (МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

9. Бусад эргэлтийн буй хөрөнгө

	2015	2014
Биет бус хөрөнгө	4,782	18,044
Хөрөнгө оруулалт	9,000	9,000
	13,782	27,044

9.1 Биет бус хөрөнгө

	2015	2014
Дансны үнэ		
1 сарын 1	18,044	35,073
Худалдан авалт	3,278	3,519
Тухайн жилийн хорогдол	(16,540)	(20,548)
12 сарын 31-нээрх цэвэр дүн	4,782	18,044

Компанийн биет бус хөрөнгө нь нягтлан бодох бүртгэлийн программ хангамжаас бүрдэж байна.

9.2 Хөрөнгө оруулалт

Компани Монгол Ноолуур ХХК-ийн хувьцааны 12.5 хувь, Монгол 999 Үндэсний Нэгдэл-ийн хувьцааны 0.1 хувийг эзэмшдэг ба Компани Монгол Ноолуур ХХК болон Монгол 999 Үндэсний Нэгдэл-д мэдэгдэхүйц нөлөөлөл үзүүлдэггүй.

Хөрөнгө оруулалтыг арилжаалах боломжтой санхүүгийн хөрөнгөөр ангилсан ба уг хөрөнгө оруулалт нь идэвхитэй зах зээл дээр арилжаалагддаггүй учраас бодит үнэ цэнийг нь найдвартайгаар тооцоолох боломжгүй бөгөөд уг хөрөнгө оруулалтыг өртгөөр нь бүртгэсэн.

10. Дансны ба бусад өглөг

	2015	2014
Дансны өглөг	275,357	3,929,716
Цалингийн өглөг	1,614,714	1,824,051
Бусад татварын өглөг (орлогын татварын өглөг ороогүй)	1,121,556	459,490
Урьдчилж орсон орлого	478,078	377,159
Хүүгийн өглөг	183,943	241,170
Ногдол ашгийн өглөг (Тодруулга 14-г үзнэ үү)	171,932	173,106
Холбоотой талд өгөх өглөг (Тодруулга 21.1-г үзнэ үү)	3,600	14,126
Бусад өглөг	33,272	22,362
	3,882,452	7,041,180

ГОВЬ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2015 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

11. Зээл

	2015	2014
Богино хугацаат зээл	26,014,975	11,357,000
Урт хугацаат зээл	23,880,000	28,357,000
	49,894,975	39,714,000

Зээлийн мөхцөл, төрлөөр:

	2015		2014	
	Богино хугацаат зээл	Урт хугацаат зээл	Богино хугацаат зээл	Урт хугацаат зээл
Барьцаат зээл				
ЕСБХ Банк (i)	2,494,975	-	2,357,000	2,357,000
Худалдаа Хөгжлийн Банк (ii)	20,120,000	9,880,000	8,500,000	11,500,000
Голомт Банк (iii)	3,400,000	14,000,000	500,000	14,500,000
Нийт зээл	26,014,975	23,880,000	11,357,000	28,357,000

11.1 Зээлийн гэрээний хураангуй

(i) Компани Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХ Банк)-наас 2009 болон 2012 онд харгалзан 3,500,000 ам.доллар болон 5,000,000 ам.долларын зээлийг төлбөрийн чадвар болон ажлын капиталаа нэмэгдүүлэхээр авсан. Уг зээлүүдийн жилийн хүү нь харгалзан 6 сарын LIBOR хүү+9.0% болон 6 сарын LIBOR хүү+6.5% ба нэхмэлийн үйлдвэр болон тоног төхөөрөмжөө барьцаалсан байна (тодруулга 8-г харна уу). Компани 3,500,000 ам долларын зээлийг 2014 оны 2 сард бүрэн төлж дууссан ба 5,000,000 ам долларын зээл нь 2016 оны 7 сард бүрэн төлөгдөж дуусна.

(ii) Компани 2011 онд жилийн 6 хувийн хүүтэй 10 тэрбум төгрөгийн, 2012 онд жилийн 7 хувийн хүүтэй 10 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл авсан. 2015 онд нэмж 10 тэрбум төгрөгийн болон 5 тэрбум төгрөгийн зээлүүдийг 9 хувийн хүүтэйгээр нэмж авсан. Энэхүү зээлүүд нь Засгийн Газраас дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих бодлогын хүрээнд гаргаж буй зээлүүд юм. Уг зээлүүдийг 2015 оны 8 сараас эхлэн буцаан төлөх бөгөөд 2018 оны 12 сард бүрэн төлж дуусах гэрээтэй байна (тодруулга 8-г харна уу).

(iii) Компани 2013 онд жилийн 8 хувийн хүүтэй 5 тэрбум төгрөгийн, 2014 онд жилийн 8 хувийн хүүтэй 10 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл авсан. 2015 онд 3 тэрбум төгрөгийн зээлийг 8 хувийн хүүтэйгээр нэмж авсан. Эдгээр зээл нь Засгийн Газраас дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих бодлогын хүрээнд гаргаж буй зээл юм. Эдгээр зээлүүдийг 2016 оны 8-р сараас эхлэн буцаан төлж эхлэх бөгөөд 2017 оны 11-р сард бүрэн төлж дуусах гэрээтэй байна. Энэхүү зээлэнд барилга болон газрын эрхээ барьцаалсан байна (тодруулга 8-г харна уу).

12. Урт хугацаат өглөг

	2015	2014
Шимт Сейки	-	158,659

ГОВЬ ХК
 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2015 ОН
 (МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

13. Хувьцаат капитал

	Хувьцааны тоо		Хувьцаат капитал	
	2015	2014	2015	2014
Эхний болон эцсийн үлдэгдэл	7,801,125	7,801,125	780,113	780,113

2015 болон 2014 оны 12 сарын 31-нээрх Компанийн 780,112.5 мянган төгрөгийн хувьцаат капитал нь нэг бүр нь 100 төгрөгийн үнэтэй 7,801,125 ширхэг зөвшөөрөгдсөн ба гаргасан хувьцаанаас бүрдэж байна.

Компани нь Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж, улсын бүртгэлийн 2076357 тоот регистрийн дугаартай гэрчилгээ авсан болно.

14. Ногдол ашиг

	2015	2014
Ногдол ашгийн өглөгийн эхний үлдэгдэл	173,106	173,723
Зарласан ногдол ашиг	1,092,157	1,014,144
Ногдол ашгийн төлөлт	(1,093,331)	(1,014,761)
Ногдол ашгийн өглөгийн эцсийн үлдэгдэл	171,932	173,106

2015 оны 2-р сарын 12-ний өдрийн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор нэгж хувьцаанд 140 төгрөг (нийт 1,092,157 мянган төгрөг)-ийн ногдол ашиг зарласан (2014 онд нэгж хувьцаанд 130 төгрөгийн, нийтдээ 1,014,144 мянган төгрөгийн ногдол ашиг зарласан).

15. Нэгж хувьцаанд хувьцаанд ногдох ашиг

	2015	2014
Тайлант жилийн ашиг (мянган төгрөгөөр)	10,747,883	10,491,809
Энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо	7,801,125	7,801,215
Нэгж хувьцаанд ногдох ашиг (мянган төгрөгөөр)	1.38	1.34

16. Орлогын татварын зардал

	2015	2014
Тайлант жилийн татварын зардал:		
Тайлант жилийн орлогын татварын зардал	2,725,512	2,885,520
Хойшлогдсон татварын зардал:		
Тайлант жилд тооцсон хойшлогдсон татварын зардал	179,771	4,344
	2,905,283	2,889,864

ГОВЬ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2015 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

16. Орлогын татварын зардал (үргэлжлэл)

16.1 Тайлант жилийн татвар

Тайлант жилийн татварын зардлыг санхүүгийн тайлангаарх цэвэр ашгаас тооцсон тохируулга:

	2015	2014
Санхүүгийн тайлангаарх татварын өмнөх цэвэр ашиг	13,653,166	13,381,673
Татварын өмнөх ашгаас татварын хувь хэмжээгээр тооцсон татварын зардал	3,413,292	3,345,418
Татвар ногдохгүй орлогын нөлөөлөл	(115,019)	(121,686)
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын нөлөөлөл	149,925	209,618
Хүүгийн орлогын татварын нөлөөлөл	(242,975)	(93,686)
Татварын бага хувь хэмжээний нөлөөлөл	(450,000)	(450,000)
Үл хөдлөх хөрөнгө барлуулсны орлогын нөлөөлөл	150,000	-
Нийт орлогын татварын зардал	2,905,283	2,889,864

Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу 3 тэрбум төгрөг хүртэлх албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 10 хувиар, 3 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 3 тэрбум төгрөгөөс дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж албан татвар ногдуулдаг.

16.2 Орлогын татварын өглөг

	2015	2014
Эхний үлдэгдэл	520,705	267,094
Тайлант жилийн татварын зардал	2,725,512	2,885,520
Суутган тооцох татварын буцаалт	(136,904)	-
Төлсөн орлогын татвар	(2,601,190)	(2,631,909)
Эцсийн үлдэгдэл	508,123	520,705

16.3 Хойшлогдсон татварын хөрөнгө

Хойшлогдсон татварын хөрөнгө нь гадаад валютаар үүссэн мөнгө болж хөрвөх хөрөнгө болон өр төлбөрийн ханшийн тэгшитгэлийн улмаас үүссэн татвар ногдох эсвэл татвараас хасагдах түр зөрүүтэй холбоотой.

2015	Эхний үлдэгдэл	Хойшлогдсон татварын ашиг/(алдагдал)	Эцсийн үлдэгдэл
Хойшлогдсон татварын хөрөнгө:			
Мөнгөн зүйлсийн хөрөнгө	(4,605)	4,170	(435)
Мөнгөн зүйлсийн өр төлбөр	394,112	(183,941)	210,171
	389,507	(179,771)	209,736
2014	Эхний үлдэгдэл	Хойшлогдсон татварын ашиг/(алдагдал)	Эцсийн үлдэгдэл
Хойшлогдсон татварын хөрөнгө:			
Мөнгөн зүйлсийн хөрөнгө	11,637	(16,242)	(4,605)
Мөнгөн зүйлсийн өр төлбөр	382,214	11,898	394,112
	393,851	(4,344)	389,507

ГОВЬ ХК
 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2015 ОН
 (МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

17. Борлуулалтын орлого ба борлуулсан бүтээгдэхүүний өртөг

17.1 Борлуулалтын орлого

	2015	2014
Сүлжмэл бүтээгдэхүүн	46,002,650	44,561,267
Нэхмэл бүтээгдэхүүн	14,425,094	12,263,371
Оёмол бүтээгдэхүүн	9,593,580	7,430,355
Бусад	2,758,292	2,351,973
	72,779,616	66,606,966
Борлуулалтын буцаалт болон хөнгөлөлт	(1,568,756)	(672,396)
	71,210,860	65,934,570

17.2 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

	2015	2014
Сүлжмэл бүтээгдэхүүн	27,168,825	26,732,926
Нэхмэл бүтээгдэхүүн	7,845,248	6,477,863
Оёмол бүтээгдэхүүн	6,113,818	4,515,870
Бусад	2,145,141	1,873,755
	43,273,032	39,600,414

18. Санхүүгийн ба бусад орлого

	2015	2014
Хүүгийн орлого	1,619,431	624,571
Түрээсийн ба бусад орлого	252,041	208,439
	1,871,472	833,010

19. Бусад олз ба (гарз)

	2015	2014
Гадаад валютын ханшийн зөрүүгийн (гарз)	(170,331)	(125,098)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/(гарз)	462,778	(91,065)
	292,447	(216,163)

ГОВЬ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2015 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

20. Борлуулалтын ба ерөнхий удирдлагын зардал

	2015	2014
Цалин ба түүнтэй холбоотой зардлууд	4,313,344	3,904,804
Маркетингийн зардал	3,272,115	2,672,201
Хангамжийн зардал	694,231	536,247
Банкны шимтгэл	653,264	563,655
Зөвлөх үйлчилгээний хөлс	481,920	585,266
Элэгдлийн зардал	471,945	384,347
Түрээсийн зардал	409,238	363,430
Томилолтын зардал	383,875	371,714
Засвар үйлчилгээ зардал	264,228	255,043
Ашиглалтын зардал	189,086	115,299
Харуул, хамгаалалтын зардал	186,613	158,297
Хөдөлмөр хамгааллын зардал	162,563	115,742
Түлш, шатахууны зардал	161,220	61,429
Тээврийн зардал	154,269	109,111
Харилцаа холбооны зардал	39,302	44,345
Даатгалын зардал	33,062	18,971
Найдваргүй авлагын хасагдуулгын зардал/(нөхөлт)	24,054	(3,096)
Бараа материалын хасагдуулгын нөхөлт	(68,714)	(386,945)
Бусад зардал	641,866	880,021
	12,467,481	10,749,881

21. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба үлдэгдэл

21.1 Холбоотой талуудын үлдэгдэл

Тайлант хугацааны эцэст холбоотой талуудын үлдэгдэл дараах үлдэгдэлтэй байна:

	2015	2014
Холбоотой талаас авах авлага:		
Таван Богд Трейд ХХК	7,397,789	-
Таван Богд Трейд ХХК-н охин компаниуд	500	500
Хувьцаа эзэмшигчид өгсөн урьдчилгаа	-	53,988
	7,398,289	54,488
Холбоотой талд өгөх өглөг:		
Таван Богд Трейд ХХК-н охин компаниуд	3,600	14,126
	3,600	14,126

21. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба үлдэгдэл (үргэлжлэл)

21.2 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

Дараах ажил гүйлгээнүүдийг холбоотой талуудтай хийсэн:

	2015	2014
Холбоотой талд өгсөн санхүүжилт	17,397,789	13,500,700
Холбоотой талаас авсан санхүүжилт	10,000,000	25,342,300
Холбоотой талтай хийсэн борлуулалт	45,918	98,321
Хүүгийн орлого	658,043	515,480
Хүүгийн зардал	26,220	11,620
Холбоотой талаас авсан худалдан авалт	965,042	1,041,824
Түрээсийн орлого	145,540	111,908
Түрээсийн зардал	63,172	55,747

Холбоотой талуудтай хийгдсэн бүх гүйлгээ нь зах зээлийн нөхцлөөр хийгдсэн.

Компани холбоотой талуудад жилийн 6.5 хувиас 12.8 хувийн хүүтэй богино хугацаат санхүүжилт олгосон. Борлуулалт болон худалдан авалт нь өнөөгийн зах зээлийн нөхцлөөр хийгддэг. Борлуулалт, худалдан авалтын зээлийн нөхцөл нь дунджаар 30 хоног ба төлөлтийн өдрийг гэрээн дээр тохиролцсон байдаг. Борлуулалт, худалдан авалтаас үүссэн авлага, өглөгийн үлдэгдэлд хүү боддоггүй.

21.3 Үндсэн удирдлагын цалин, урамшуулал

Үндсэн удирдлага болон удирдлагын багийн гишүүдийн тайлант үеийн цалин, урамшуулал дараах байдалтай байна. Үүнд:

	2015	2014
Тайлант үеийн цалин урамшуулал	759,358	778,881

22. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдлийн удирдлага

Компанийн санхүүгийн үндсэн хэрэгслүүд нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, дансны ба бусад авлага, дансны ба бусад өглөг мөн банкны зээлээс бүрддэг. Компани нь үйл ажиллагаагаа санхүүжүүлэхийн тулд эдгээр санхүүгийн хэрэгслүүдийг эзэмшдэг.

Компани арилжаалах болон санхүүгийн хамгаалалт хийх зорилгоор санхүүгийн хэрэгслүүдийг эзэмшдэггүй болно.

Компанийн санхүүгийн хэрэгслээс үүсэлтэй үндсэн эрсдлүүдийг хүүгийн эрсдэл, гадаад валютын эрсдэл, зээлийн эрсдэл болон төлбөрийн чадварын эрсдэл гэж ангилж болно.

Компанийн эрсдлийн удирдлагын бодлогыг хураангуйлан өгүүлбэл:

22.1 Зээлийн эрсдлийн удирдлага

Компанийн харилцагчид зээлийн нөхцлөөр худалдан авалт хийгээд түүнийгээ төлж чадахгүй болсноор Компанид санхүүгийн хохирол учрах зээлийн эрсдлийг үүсгэдэг. Одоогийн байдлаар зах зээлд хараат бус үнэлгээний байгууллага байхгүй байна. Иймээс Компанийн зүгээс баримталдаг зээлийн борлуулалтын бодлогын дагуу удаан хугацаанд харилцсан, найдвартай харилцагчдад зээлийн лимит олгож баталдаг. Жил бүр худалдан авагчтай хийсэн борлуулалтын гэрээг шинэчилж гэрээний хэрэгжилтийг байнга хянадаг.

22. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

2014 болон 2015 оны 12-р сарын 31-ний байдлаарх зээлийн эрсдэл:

	Дансны үнэ	
	2015	2014
Банкин дахь мөнгө ба хадгалэмж	17,899,293	16,113,854
Дансны авлага	3,755,755	3,243,415
Холбоотой талуудаас авах авлага	7,398,289	54,488
Бусад авлага	128,294	35,975
	29,181,631	19,447,732

Дансны авлагын үлдэгдлийн 48 хувийг гадаадын 5 том худалдан авагч эзэлж байна (2014 онд: 54%).

Дансны авлагын нөхцөл байдлыг үндэслэн зээлийн үнэлгээг тогтмол хийдэг ба шаардлагатай гэж үзвэл төлбөрийн эрсдлийг даатгуулдаг. Мөн Компани худалдан авагчаас дараагийн захиалгыг гүйцэтгэхээс өмнө үлдэгдэл төлбөрөө төлсөн байхыг шаарддаг.

Компанид гуравдагч талд санхүүгийн баталгаа гаргаагүй.

Компани тайлант хугацааны эцсээрх дансны ба бусад авлагад барьцаа аваагүй.

22.2 Хөрвөх чадварын эрсдлийн удирдлага

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь Компани өөрийн санхүүгийн өр төлбөрийг барагдуулах үүргээ биелүүлэхэд хүндрэлтэй болох эрсдэл юм. Компани нь хэвийн болон онцгой нөхцөлд их хэмжээний алдагдалд орохгүйгээр, Компанийн нэр хүндэд хохирол учруулах эрсдэлийг бий болгохгүйгээр өр төлбөрөө гэрээний хугацаанд төлж барагдуулахад хүрэлцэхүйц хөрвөх чадварыг байнга барьж байх ёстой гэдэг зарчмаар хөрвөх чадварыг удирдан зохицуулдаг.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь хөрвөх чадварын эрсдлийн удирдлагыг хариуцдаг ба Компанийн богино, дунд ба урт хугацааны санхүүжилт болон хөрвөх чадварын эрсдлийн удирдлагын шаардлагад нийцсэн хөрвөх чадварын бүтцийг бий болгох үүрэгтэй. Компани санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн төлөгдөх хугацаа, банкнаас зээл авах чадавхи, зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл, мөнгөн урсгалын таамаглал болон гүйцэтгэлд үндэслэн хөрвөх чадварын эрсдлийг удирддаг.

Хүснэгтэнд Компанийн дериватив бус санхүүгийн өр төлбөрийг гэрээгээрх төлөх хугацаагаар нь ангилан тайлагнасан. Энэхүү хүснэгтийн дүнгүүд нь үндсэн төлбөр болон хүүг агуулсан болно. Хүснэгтэн дэх мэдээлэл нь Компанийн төлбөр төлөх шаардлагатай хэмгийн эхний хугацаанд үндэслэсэн дискаунтлаагүй мөнгөн гүйлгээг харуулж байна.

	Жигнэсэн дундаж хүүгийн түвшин	1 сараас бага	1-3 сар	3 сараас 1 жил	1-5 жил	Нийт	Дансны үнэ
2015 оны 12 сарын 31							
Хүүгүй хэрэглүүр	-	1,879,233	200,302	203,283	-	2,282,818	2,282,818
Хувьсах хүүтэй хэрэглүүр	6.50%	1,255,929	13,329	1,269,703	-	2,538,961	2,494,975
Тогтмол хүүтэй хэрэглүүр	7.89%	327,787	634,850	26,046,954	26,217,008	53,226,599	47,400,000
		3,462,949	848,481	27,519,940	26,217,008	58,048,378	52,177,793

ГОВЬ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2015 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

22. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

22.2 Хөрвөх чадварын эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

	Жигнэсэн дундаж хүүгийн түвшин	1 сараас бага	1-3 сар	3 сараас 1 жил	1-5 жил	Нийт	Дансны үнэ
2014 оны 12 сарын 31							
Хүүгүй хэрэглүүр	-	2,274,815	3,705,520	224,196	158,659	6,363,190	6,363,190
Хувьсах хүүтэй хэрэглүүр	6.5%	1,193,253	39,564	1,323,796	2,401,706	4,958,319	4,714,000
Тогтмол хүүтэй хэрэглүүр	7%	120,396	415,795	10,858,519	28,530,121	39,924,831	35,000,000
		3,588,464	4,160,879	12,406,511	31,090,486	51,246,340	46,077,190

Дараах хүснэгтэнд Компанийн дериватив бус санхүүгийн хөрөнгийг гэрээгээрх төлөгдөх хугацаагаар нь ангилан тайлагнасан. Хүснэгтэн дэх мэдээлэл нь Компанийн санхүүгийн хөрөнгө болон хүүгийн төлбөрийн дискаунтлаагүй мөнгөн гүйлгээг харуулж байна. Энэхүү дериватив бус санхүүгийн хөрөнгийн мэдээллийг хөрвөх чадварын эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ цэвэр хөрөнгө өр төлбөрийн позицид тулгуурладаг тул энд харгалзан үзэх хэрэгтэй юм.

	Жигнэсэн дундаж хүүгийн түвшин	1 сараас бага	1-3 сар	3 сараас 1 жил	Нийт	Дансны үнэ
2015 оны 12 сарын 31						
Хүүгүй хэрэглүүр	-	327,952	1,688,693	2,385,206	4,401,851	4,401,851
Тогтмол хүүтэй хэрэглүүр	2.40%	889,172	-	-	889,172	887,398
Тогтмол хүүтэй хэрэглүүр	6.50%	-	1,115,628	-	1,115,628	1,097,789
Тогтмол хүүтэй хэрэглүүр	12.80%	1,313,867	5,160,000	-	6,473,867	6,300,000
Тогтмол хүүтэй хэрэглүүр	12.58%	-	17,128,757	-	17,128,757	16,606,649
		2,530,991	25,093,078	2,385,206	30,009,275	29,293,687

	Жигнэсэн дундаж хүүгийн түвшин	1 сараас бага	1-3 сар	3 сараас 1 жил	Нийт	Дансны үнэ
2014 оны 12 сарын 31						
Хүүгүй хэрэглүүр	-	158,375	-	3,297,903	3,456,278	3,456,278
Тогтмол хүүтэй хэрэглүүр	2.4%	1,140,587	-	-	1,140,587	1,113,853
Тогтмол хүүтэй хэрэглүүр	10.8%	135,000	15,405,000	-	15,540,000	15,000,000
		1,433,962	15,405,000	3,297,903	20,136,865	19,570,131

22. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

22.3 Зээлийн хүүгийн эрсдлийн удирдлага

Компани хөвөгч хүүгэй зээлтэй учраас зээлийн хүүгийн эрсдэлтэй. Энэхүү эрсдлийг Компани тогтмол болон хөвөгч хүүтэй зээлийн зохистой байдлыг хангах замаар удирддаг. Зээлийн хүүгийн эрсдлийг удирдахдаа хамгаалалтын хэрэглүүрийг ашигладаггүй.

Компанийн санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн хүүгийн түвшний талаар хөрвөх чадварын эрсдлийн удирдлагын хэсэгт далгэрэнгүй дурьдсан болно.

Зээлийн хүүгийн мэдрэмжийн шинжилгээ

Доор дурьдсан мэдрэмжийн шинжилгээг тайлант хугацааны эцэст байгаа дериватив бус хэрэгслүүд дэх хүүгийн түвшний нөлөөллийг үндэслэн тодорхойлсон. Хувьсах хүүтэй өр төлбөрийн шинжилгээг бэлтгэхдээ тайлант хугацааны эцэс дэх төлөгдөөгүй өр төлбөрийг тайлант хугацааны жилийн турш төлөгдөөгүй гэж үзсэн. Гүйцэтгэх удирдлагын түвшинд хүүгийн түвшний эрсдлийг үнэлэхдээ хүүгийн түвшний боломжит өөрчлөлтийг 50 функтээр өснө/буурна гэж үзсэн.

Хэрэв бүх хувьсах торцоологдох үүн тогтмол байх үед хүүгийн түвшин 50 функтээр өсч/буурвал 2015 оны 12 сарын 31-нээрх цэвэр ашиг 9,356 мянган төгрөгөөр өснө/буурна (2014 оны 12 сарын 31: 17,678 мянган төгрөг). Энэ нь Компанийн хувьсах хүүтэй зээлүүдэд хамааралтай.

22.4 Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл гэдэг нь зах зээлийн үнийн өөрчлөлт тухайлбал хүүгийн хувь, гадаад валютын ханш өөрчлөгдсөнөөр Компанийн орлого эсвэл эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрийн үнэлгээнд сөргөөр нөлөөлөх эрсдэл юм. Компани зах зээлийн үндсэн эрсдэл болох хүүгийн эрсдэл болон гадаад валютын эрсдлийг дараах дурдсанаар хянаж удирддаг.

Зах зээлийн эрсдлийн удирдлагын зорилго нь параметруудийг зөвшөөрөгдөх хэмжээнд барих, эрсдлийг бууруулахын тулд зах зээлийн эрсдлийг удирдах, хянах явдал юм.

22.4.1 Гадаад валютын эрсдлийн удирдлага

Компанид төгрөгөөс өөр валютаар үүссэн худалдан авалт болон төлбөртэй холбоотойгоор гадаад валютын ханшийн эрсдэл үүсдэг. Компани нь гадаад валютын эрсдлийг гадаад валютын дериватив хэрэгслийг ашиглан хянадаггүй.

Компанийн гадаад валютаар үүссэн мөнгө болон хөрвөх хөрөнгө ба өр төлбөрийг тайлангийн өдрийн байдлаар төгрөгөөр үзүүлбэл дараах байдалтай байна:

	2015		2014	
	Өр төлбөр	Хөрөнгө	Өр төлбөр	Хөрөнгө
Гадаад валютаар үүссэн	2,789,884	8,101,413	8,838,433	4,091,195

Гадаад валютын мэдрэмжийн шинжилгээ

Компанийн ажил гүйлгээ нь ихэнхдээ америк доллараар хийгддэг. Америк доллартай харьцах Монгол төгрөгийн ханш 10 хувиар өсөх/буурах үеийн мэдрэмжийг доорхи хүснэгтэнд харуулав. Гүйцэтгэх удирдлагын түвшинд гадаад валютын эрсдлийг үнэлэхдээ дээрх 10 хувийн мэдрэмжийг ашигладаг ба энэ нь гадаад валютын ханш дахь удирдлагын үнэлж буй боломжит өөрчлөлтийг илэрхийлнэ. Энэхүү мэдрэмжийн шинжилгээ нь зөвхөн гадаад валютаар илэрхийлэгдсэн төлөгдөөгүй байгаа мөнгө болж хөрвөх санхүүгийн үзүүлэлтүүд болон тайлант хугацааны эцэс дэх гадаад валютын ханшийн 10 хувийн өөрчлөлтийн нөлөөллийг агуулдаг.

22. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

22.4.1 Гадаад валютын эрсдлийн удирдлага (үргэлжлэл)

Хэрэв санхүүгийн тайлангийн өдрөөр төгрөгийн ханш бусад валютын эсрэг 10%-иар чангарахад Компанийн татварын дараах ашиг дор хүснэгтэнд үзүүлснээр өснө. Энэхүү шинжилгээнд бусад бүх хувьсах үзүүлэлтүүдийг тогтмол гэж үзсэн.

	2015	2014
Татварын дараах ашигт үзүүлэх нөлөөлөл	(531,153)	474,724

Санхүүгийн тайлангийн өдрөөр бусад бүх үзүүлэлтүүд тогтмол байх үед төгрөгийн ханш бусад валютын эсрэг 10%-иар сулрахад Компанийн татварын дараах ашигт үзүүлэх нөлөөлөл дээрх дүнтэй тэнцүү боловч эсрэг нөлөө үзүүлэх юм.

22.5 Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнэ

22.5.1 Бодит үнэ цэнээрээ тусгагдаагүй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ

Компани санхүүгийн тайланд бодит үнэ цэнээрээ тусгагдаагүй тэдгээр санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг дараах байдлаар тодорхойлсон.

(i) Бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүд

Нэг жилээс доош хугацаанд төлөгдөх болон нөхөгдөх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бодит үнэ цэнэ нь тэдгээрийн дансны үнэтэйгээ ойролцоо гэж авч үзсэн.

(ii) Тогтмол хүүтэй санхүүгийн хэрэглүүр

Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг анх хүлээн зөвшөөрч бүртгэх үеийн зах зээлийн хүү болон Монголд байгаа ижил төстэй санхүүгийн хэрэглүүрийн одоогийн хүүг харьцуулж тодорхойлдог. Зээл олгогдсон тохиолдолд, бодит үнэ цэнийг хэмжихдээ зах зээл дээрээс тооцоололд ашиглагдах хүчин зүйлсүүдийг олж авах боломжгүй үед, мөнгөн гүйлгээг дискаунтлах аргыг ашигладаг.

Компанийн санхүүгийн хэрэглүүр нь зээл ба авлага болон бусад хорогдуулсан өртгөөр бүртгэсэн өр төлбөрөөс бүрдэнэ.

Удирдлага санхүүгийн тайланд тусгагдсан тэдгээр санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ нь бодит үнэ цэнэтэй ойролцоо гэж үзэж байна.

23. Сегментийн мэдээлэл

Компанийн удирдлага худалдан авагчдын төрөл, байршил, борлуулалтын хүргэлт болон төрөлд үндэслэн борлуулалтын орлого болон борлуулалтын өртгийг "Дотоод борлуулалт" болон "Экспортын борлуулалт" гэсэн үйл ажиллагааны 2 сегментээр ангилж, удирдлагын шинжилгээ болон шийдвэр гаргалтандаа ашигладаг. Дээрх 2 сегментээс өөр сегментийн мэдээллийг бэлтгэж ашигладаггүй. Дээрх сегментээр ангилсан борлуулалтын орлого болон борлуулсан бүтээгдэхүүний өртгөөс бусад орлого зардлыг сегментээр ангилж тайлагнадаггүй. Үүнтэй адилаар нийт хөрөнгө болон өр төлбөрийг сегментээр ангилж тайлагнадаггүй.

23.1 Сегментийн орлого ба борлуулалтын өртөг

		2015		2014	
		Дотоодын борлуулалт	Экспортын борлуулалт	Дотоодын борлуулалт	Экспортын борлуулалт
Орлого		43,137,192	28,073,668	40,342,954	25,591,616
Борлуулалтын өртөг		24,400,969	18,872,063	20,788,695	18,811,719
Нийт ашиг		18,736,223	9,201,605	19,554,259	6,779,897
				2015	2014
Орлого:					
Дотоод борлуулалт:	Сүлжмэл бүтээгдэхүүн			24,569,616	23,934,367
	Нэхмэл бүтээгдэхүүн			8,351,350	8,796,412
	Оёмол бүтээгдэхүүн			7,946,711	6,154,111
	Бусад			2,269,515	1,458,064
				43,137,192	40,342,954
Экспортын борлуулалт:	Сүлжмэл бүтээгдэхүүн			20,274,692	20,121,358
	Нэхмэл бүтээгдэхүүн			5,932,612	3,380,467
	Оёмол бүтээгдэхүүн			1,391,001	1,206,036
	Бусад			475,363	883,755
				28,073,668	25,591,616
				71,210,860	65,934,570
Борлуулалтын өртөг:					
Дотоод борлуулалт:	Сүлжмэл бүтээгдэхүүн			13,582,515	11,793,836
	Нэхмэл бүтээгдэхүүн			3,771,205	4,014,312
	Оёмол бүтээгдэхүүн			5,181,315	3,607,686
	Бусад			1,865,934	1,372,861
				24,400,969	20,788,695
Экспортын борлуулалт:	Сүлжмэл бүтээгдэхүүн			13,586,310	14,939,090
	Нэхмэл бүтээгдэхүүн			4,074,043	2,463,551
	Оёмол бүтээгдэхүүн			932,503	908,184
	Бусад			279,207	500,894
				18,872,063	18,811,719
				43,273,032	39,600,414

ГОВЬ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2015 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

23. Сегментийн мэдээлэл (үргэлжлэл)

Дотоод болон экспортын борлуулалтын сегментэд ногдох хөрөнгө ба өр төлбөр дараах байдалтай байна.

	2015	2014
Дансны авлага		
Дотоод борлуулалт	140,563	45,142
Экспортын борлуулалт	3,658,557	3,214,987
	3,799,120	3,260,129
Урьдчилж орсон орлого		
Дотоод борлуулалт	116,379	123,082
Экспортын борлуулалт	361,699	254,077
	478,078	377,159

24. Капиталын эрсдлийн удирдлага

Компани тасралтгүй үйл ажиллагаа явуулах зорилгоор өөрийн капиталыг удирдахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчийн өгөөжийг хамгийн ихээр байлгахын тулд зээл болон өөрийн хөрөнгийн харьцааг оновчтой байлгахыг зорьдог. Компанийн нийт стратегийн бодлого 2014 оныхоос өөрчлөгдөөгүй байна.

Компанийн капиталын бүтэц нь зээл ба өөрийн хөрөнгөөс бүрдэх бөгөөд зээл нь санхүүгийн бус өр төлбөрөөс бусад богино болон урт хугацаат өр төлбөрөөс, өөрийн хөрөнгө нь дүрмийн сан, нөөц ба хуримтлагдсан ашгаас тус тус бүрддэг.

25. Гэрээний үүрэг

Компанид 2015 болон 2014 оны 12 сарын 31-ний байдлаар томоохон капитал худалдан авалтын үүрэг байхгүй.

26. Болзошгүй өр төлбөр

26.1 Болзошгүй өр төлбөр

Хэвийн бизнесийн үйл ажиллагааны явцад Компани нь хууль, эрх зүйн асуудлууд, гомдол нэхэмжлэлд өртөж болно. Ийм хууль, эрх зүйн асуудал, гомдол нэхэмжлэл байгаа бол түүнээс гарах үүрэг хариуцлага нь Компанийн ирээдүйн үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн байдалд их хэмжээний сөрөг үр дагаврыг бий болгохгүй гэж Компанийн удирдлага итгэж байна.

26.2 Татварын систем

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилттэй холбоотойгоор Монголын Засгийн Газар бизнес болон эдийн засгийн бүтцэд өөрчлөлт шинэчлэлтийг хийсээр байна. Үүний үр дүнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдсөөр байна.

Өөр өөр эрх бүхий байгууллагууд татварын хуулийн хэрэгжүүлэлтэнд хяналт шалгалт хийж төлбөр торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Компани татварын хууль тогтоомжийн ойлголт дээрээ үндэслэн бүх татваруудыг үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч дээр дурдсан хүчин зүйлүүдээс үндэслэн Компанид татварын эрсдэл байсаар байна.

27. Тайлангийн дараах үйл явдал

2016 оны 1-р сарын 21-ний өдрийн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор нэгж хувьцаанд 140 төгрөг (нийт 1,092,158 мянган төгрөг)-ийн ногдол ашиг зарласан. Дээрх ногдол ашиг зарласнаас өөр санхүүгийн тайлангуудад нөлөөлөхүйц, тодруулахыг шаарддаг тайлангийн дараах үйл явдал гараагүй.

2016 оны 2-р сарын 26

Говь ХК
Монгол Улс,
Улаанбаатар хот-17062,
Хан-Уул дүүрэг, 3-р хороо
Говь Хувьцаат Компанийн байр

Тодорхойлолт

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчид танаа,

Бид Говь ХК (цаашид "Компани" гэх) -ийн 2015 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн тайлангийн аудитдаа үндэслэн, Говь ХК-ийн 2015 онд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлүүд нь "Компанийн тухай" хуулийн 92-р зүйлд заасны дагуу хийгдсэн гэдгийг тодорхойлж байна.

Хавсралт 1-д сонирхлын зөрчилтэй этгээдүүдтэй хийсэн гүйлгээ болон үлдэгдлийг хавсаргав.



Тим Махон
Аудитын Партнер
Делоитт Онч Аудит ХХК
Улаанбаатар хот, Монгол Улс
2016 оны 2 дугаар сарын 26



Хавсралт 1. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба үлдэгдэл

1.1 Холбоотой талуудын үлдэгдэл

Тайлант хугацааны эцэст холбоотой талуудын үлдэгдэл дараах үлдэгдэлтэй байна:

	2015	2014
Холбоотой талаас авах авлага:		
Таван Богд Трейд ХХК	7,397,789	-
Таван Богд Трейд ХХК-н охин компаниуд	500	500
Хувьцаа эзэмшигчээс авах авлага	-	53,988
	7,398,289	54,488
Холбоотой талд өгөх өглөг:		
Таван Богд Трейд ХХК-н охин компаниуд	3,600	14,126
	3,600	14,126

1.2 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

Дараах ажил гүйлгээнүүдийг холбоотой талуудтай хийсэн:

	2015	2014
Холбоотой талд өгсөн санхүүжилт	17,397,789	13,500,700
Холбоотой талаас авсан санхүүжилт	10,000,000	25,342,300
Холбоотой талтай хийсэн борлуулалт	45,918	98,321
Хүүгийн орлого	658,043	515,480
Хүүгийн зардал	26,220	11,620
Холбоотой талаас авсан худалдан авалт	965,042	1,041,824
Түрээсийн орлого	145,540	111,908
Түрээсийн зардал	63,172	55,747

Холбоотой талуудтай хийгдсэн бүх гүйлгээ нь зах зээлийн нөхцлөөр хийгдсэн.

Компани холбоотой талуудад жилийн 6.5 хувиас 12.8 хувийн хүүтэй богино хугацаат санхүүжилт олгосон. Борлуулалт болон худалдан авалт нь өнөөгийн зах зээлийн нөхцлөөр хийгддэг. Борлуулалт, худалдан авалтын зээлийн нөхцөл нь дунджаар 30 хоног ба төлөлтийн өдрийг гэрээн дээр тохиролцсон байдаг. Борлуулалт, худалдан авалтаас үүссэн авлага, өглөгийн үлдэгдэлд хүү боддоггүй.

1.3 Үндсэн удирдлагын цалин, урамшуулал

Үндсэн удирдлага болон удирдлагын багийн гишүүдийн тайлант үеийн цалин, урамшуулал дараах байдалтай байна. Үүнд:

	2015	2014
Тайлант үеийн цалин урамшуулал	759,358	778,881

МЭНДЧИЛГЭЭ

“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ЭРХЭМ ХҮНДЭТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ЭЭ!

“Говь” ХК өнгөрөгч 2015 онд тоног төхөрөөмжийн шинэчлэлтийг амжилттайгаар үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, бүтээмжээ нэмэгдүүлэн дотооддоо болон дэлхийн зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ таниулж зах зээлээ өргөтгөн ажиллалаа. Өдгөө та бүхэнд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээллийг ном болгон хүргэж байна.

“Говь” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2016 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 14:00 цагт Хан-уул дүүргийн 3-р хороо, Говь компанийн төв дэлгүүрийн дэргэдэх “Мираж” гэр ресторанд болно.

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2015 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанид шинээр нэвтрүүлээд байгаа Амёб менежментийн явц, үр дүнг танилцуулах
3. 2014 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2015 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах
4. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж батлах
5. ТУЗ-н гишүүнд нэр дэвшигчдийг батлах

Саналын хуудсаар урьдчилан санал өгөх хүмүүс энэхүү номтой танилцан, саналын хуудсаа бөглөж, брокер диллерийн компанидаа эсвэл “Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, Говь ХК” хаягаар 2016 оны 4 дүгээр сарын 4-ны өдрөөс өмнө ирүүлнэ үү.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээх
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Д.Хүрэлбаатар 3 минут
2. Тооллогын комисс болон редакцийн комиссыг томилсон тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг танилцуулах
Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга 3 минут
3. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу дараах илтгэлүүдийг тавина:
 - a. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2015 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг танилцуулах
Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан 10 минут
 - b. Компанид шинээр нэвтрүүлж буй менежментийг танилцуулах
Тэргүүн дэд захирал Д.Наранбаатар 10 минут
 - c. Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг танилцуулах
Хуулийн зөвлөх Ц.Цасчихэр 3 минут
 - d. 2014 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2015 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТҮЗ-ийн шийдвэрийг танилцуулах
Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга 3 минут
 - e. Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн товч танилцуулга
Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга 5 минут
4. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт: Хүн тус бүр 3 минут
5. Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон санал, шүүмжлэл: Хүн тус бүр 3 минут
6. Саналын хуудсаар санал авах 5 минут
7. Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээний дэвшилттэй талыг харуулсан загварын шоу 20 минут
8. Санал хураалтын дүнг нэгтгэн, тооллогын комисс саналт хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах 5 минут
9. Хурлаас гарах шийдвэрийн төсөлд Хувьцаа эзэмшигчдийн санал асуулгын дүнг тусган редакцийн комиссын дарга танилцуулж төслийг батлуулах 10 минут

Хурлын үргэлжлэх хугацаа: 2 цаг.

Жич: Хэрэв шаардлагатай бол хурлын хугацааг хэлэлцэн сунгаж болно.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

ХУРАЛД ОРОЛЦОХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ, УГ БИЧИГ БАРИМТТАЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ ГАЗАР, ХУГАЦАА

Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2016 оны 3 сарын 6-ны өдрөөс эхлэн 4 дүгээр сарын 6-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдийн 09.00-17.00 цагийн хооронд “Говь” ХК-ийн төв байранд байрлах Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын өрөөнд ирж танилцаж болно.

Хувьцаа эзэмшигчид нь дор дурдсан бичиг баримттай танилцаж болно. Үүнд:

1. Компанийн санхүүгийн жилийн тайлан
2. Санхүүгийн жилийн тайлангийн талаархи аудитын байгууллагын дүгнэлт
3. Тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнийг компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийгдсэн эсэх тухай аудитын байгууллагын дүгнэлт
4. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд, тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо
5. ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал, бусад зардал
6. Компанийн бизнесийн үйл ажиллагааны тайлан
7. ТУЗ-н гишүүнд нэр дэвшигчийн танилцуулга

“ГОВЬ” ХК-ИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Хүрэлбаатар

“Говь” Хувьцаат компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2016 оны зорилтын талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, “Говь” ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа Эзэмшигчидийн хуралд танилцуулж байна.

“Говь” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2015 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэж баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдөж, Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан 2015 оны бизнес төлөвлөгөөний гол зорилго нь түүхий эд бэлтгэлийн ажлыг сайтар зохион байгуулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлж үргүй зардал гаргахгүй ажиллах, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, өр авлагыг цаг хугацаанд нь барагдуулж, санхүүгийн сахилга батыг өндөржүүлэх, техник технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх, гадаад, дотоодын хэрэглэгчдийнхээ эрэлт хэрэгцээг мэдэрсэн бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагч үйлчлүүлэгчдэдээ цаг алдалгүй хүргэх, борлуулалтыг нэмэгдүүлэн, үр ашгаа өсгөж ажиллахад чиглэсэн удирдлагаар компанийг удирдан зохион байгуулах явдал байсан билээ.

Хэдийгээр өнгөрсөн онд Монгол улсын эдийн засгийн өсөлт тааруу, хямралтай жил болсон ч Говь хувьцаат компани 2015 онд 71 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж бизнес төлөвлөгөөгөө 90%-аар, цэвэр ашгийг 15.0 тэрбум төгрөгөөр төлөвлөснийг 71%-аар тус тус биелүүлсэн. Монгол улсын Засгийн газраас ноолуурын салбарыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрлэгчдэд тулгардаг эргэлтийн хөрөнгийн асуудлыг хөнгөлөлттэй зээл олгох замаар шийдвэрлэсэн бөгөөд манай компани энэхүү хөнгөлөлттэй зээлд хамрагдаж ирэх жилийн түүхий эд бэлтгэл хүртэл үйлдвэрлэлээ жигд ажиллагаагаар ханган ажиллуулж, шаардлагатай хөрөнгө оруулалтаар техник технологийн шинэчлэлийг хийж, ажлын байрыг нэмэгдүүлэн, компанийн анхан шатны үйлдвэрүүдийн хүчин чадлыг бүрэн дүүрэн ашиглан бүтээмжийг дээшлүүлж чаджээ.

Говь Хувьцаат Компанийн гүйцэтгэх удирдлагын баг 2015 онд төлөвлөгдсөн зорилтоо ханган биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд Цагаачийн Баатарсайхан, Дашдаваагийн Хулан, Такеши Камбе, Хидео Савада, Даваагийн Наранбаатар, Түнрэвийн Одмаа, Дамбийжавын Хүрэлбаатар, Дамбын Гэрэлмаа нарыг улируулан сонгох, шинээр Зуунайн Шагдарсүрэн сонгохоор нэр дэвшүүлж байна.



Овог, нэр: Цагаачийн БААТАРСАЙХАН

1966 онд Ховд аймгийн Булган суманд төрсөн, эрэгтэй

Боловсрол:

1984-1988 онд Монгол улсын Политехникийн их сургуулийг холбооны инженерээр сурч төгссөн

1988-1989 онд Япон улсын Токиогийн гадаад хэл судлалын япон хэлний ангийг төгссөн

1989-1993 Япон улсын Токио хотын Цахилгаан Холбоо, Электроникийн Их Сургуулийг электроникийн инженер мэргэжлээр бакалавр

ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

1993-1997 онд Япон Монголын хамтарсан “Алтай” компанид Орлогч захирал

1997-1999 онд Таван Богд компанийн ерөнхий захирал, Таван Богд Трейд ХХК-ийн ерөнхий захирал

1999-2000 онд Жуулчин ХХК-ийн ерөнхий захирал

2000-2001 онд “Палас” зочид буудлын Гүйцэтгэх захирал

2001-2003 онд МИАТ компанийн ерөнхий захирал

2003 оноос Таван Богд группийн ерөнхийлөгч, Жуулчин компанийн ерөнхийлөгч, Палас болон Хаан Палас зочид буудлын ТУЗ-ийн дарга

2007 оноос “Говь” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

2008 оны 8 сараас “Говь” ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гадаад хэл эзэмшсэн байдал: Япон, Англи, Орос хэлтэй



Овог, нэр: Дамба ГЭРЭЛМАА

1965 онд Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй

Боловсрол:

1982-1988 онд ЗХУ, Москва хотын Цахилгаан холбооны дээд сургууль, холбооны инженер эдийн засагч

2000-2003 онд МУ-ын ЗГ-ийн хэрэгжүүлэгч агентлаг “Удирдлагын академи” удирдахуйн ухааны доктор

ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

1988-1992 онд Радио Телевизийн Техникийн Төв эдийн засагч

1992-1994 онд Эдийн Засгийн Хөгжлийн Коллеж, Бизнес удирдлагын тэнхим, багш

1994-2003 онд Эдийн Засгийн Хөгжлийн Коллеж, Бизнес удирдлагын тэнхим, тэнхмийн эрхлэгч

2003-2006 онд МУ-с НҮБ-д суух Байнгын төлөөлөгчийн газар, Швейцарийн Холбооны улс дахь ЭСЯ, нягтлан бодогч

2006-2009 онд СЭЗДС, Сургалт Эрдэм Шинжилгээ эрхэлсэн дэд захирал

2009-2015 онд СЭЗДС, Сургалт эрхэлсэн дэд захирал

2015 оноос СЭЗДС, Бизнес удирдлагын тэнхмийн профессор

Гадаад хэл эзэмшсэн байдал: Англи, Орос хэлтэй



Овог, нэр: Такеши КАМБЕ

1961 онд Япон улсад төрсөн, эрэгтэй

Боловсрол:

1985 онд Кеогийн Их Сургуулийг эдийн засгийн ухааны бакалавр, магистр

ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

1985-1986 онд Нийгмийн даатгалын хамтарсан компанид хүний нөөцийн менежер

1986-1988 онд Нагано Бренчийн захиргааны менежер

1988-1989 онд Куото салбарын худалдааны менежер

1989-1992 онд Японы хамтын ажиллагааны банкны Гадаадын хамтын ажиллагааны эдийн засгийн фондын зээлийн мэргэжилтэн, Азийн хөгжлийн банк болон Дэлхийн Банкны хамтран хэрэгжүүлсэн Бангладеш улсад хэрэгжүүлсэн Жамнагийн олон зорилтот гүүрийн төсөл, Шриланк улсад хэрэгжүүлсэн Их Коломбийн харилцаа холбоог боловсронгуй болгох төсөл, Мянмариин Олон улсын харилцаа холбооны шугамыг шинэчлэх төсөлд тус тус ажиллаж байсан.

1992-1995 онд Азийн даатгалын компанийн Олон улсын хөрөнгө оруулалтын газрын хөрөнгө оруулалтын санхүүжилт зээлийн менежер

1995-1998 онд Гонгконг дахь азийн хөрөнгө оруулалтын удирдагч

1998-1999 онд АНУ-ын даатгалын хамтын ажиллагааны бүртгэлийн ухааны сургалтанд хамрагдсан

1999-2000 онд Азийн даатгалын хамтарсан компанийн Удирдлагын зөвлөлийн дарга

2000-2002 онд Азийн үл хөдлөх хөрөнгө ХХК-ийн зээлийн болон судалгаа шинжилгээний менежер

2001-2003 онд Номхон далайг хамгаалах нийгэмлэгийн гишүүнээр сонгогдсон
2002-2006 онд Азийн даатгалын хамтарсан компанийн жижиг дунд корпорациудад арилжааны зээл олгох асуудлыг хариуцсан менежер
2006 оноос Азийн даатгалын хамтарсан компанийн үл хөдлөх хөрөнгийн арилжааны хяналтын менежер

Гадаад хэл эзэмшсэн байдал: Англи, Орос хэлтэй



Овог, нэр: Даваа НАРАНБААТАР

1982 онд төрсөн, эрэгтэй

Боловсрол:

1999-2003 онд Худалдаа Үйлдвэрлэлийн дээд сургуулийг нягтлан бодогч, эдийн засагч мэргэжлээр бакалавр

ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

2002-2003 онд Таван Богд Косметикс ХХК-д өрөлтийн менежер

2003-2004 онд Таван Богд Косметикс ХХК-д судалгааны менежер, ахлагч

2004-2005 онд Таван Богд Косметикс ХХК-д дэд захирал

2005-2008 онд Таван Богд Косметикс ХХК-ийн бизнес төлөвлөлтийн хэлтсийн дарга

2008 онд “Говь” ХК-ийн дотоод худалдааны газрын захирал

2009 оноос “Говь” ХК-ийн тэргүүн дэд захирал

Гадаад хэл эзэмшсэн байдал: Англи хэлтэй



Овог, нэр: Түнрэв ОДМАА

1976 онд Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй

Боловсрол:

1993-1996 онд Европын хэлний дээд сургууль, бакалавр

1996-1999 онд Энэтхэг улс, Делигийн Их Сургууль, эдийн засагч, бакалавр

2007-2008 онд Герман улс, Потсдамын Их Сургууль, Төрийн удирдлагын магистр

ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

2000-2003 онд Монгол Шуудан банк, Гадаад харилцаа, маркетинг мэдээлэл судалгааны газарт захирал, гадаад харилцааны менежер

2003-2004 онд Дэлхийн банк, АХБ-аас хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, Дотоодын зөвлөх, орчуулагч

2004-2005 онд Капитрон банк, Гадаад харилцааны хэлтэс, Захирал

2005-2006 онд Дэлхийн банк, АХБ-аас хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, Дотоодын зөвлөх

2006-2007 онд Ланддорффинанс ББСБ, Зээлийн эдийн засагч

2008-2010 онд Хадгаламж банк, Хамтын ажиллагаа, сурталчилгаа идэвхжүүлэлтийн хэлтэс, захирал

2010 оноос Ланддорффинанс ББСБ-н гүйцэтгэх захирал

Гадаад хэл эзэмшсэн байдал: Англи, Орос хэлтэй

Овог, нэр: Хидео САВАДА



1951 онд Япон улсын Осака хотод төрсөн, эрэгтэй

Боловсрол:

1973-1976 онд Герман улсын Майнзын Их Сургуулийг эдийн засагч мэргэжлээр бакалавр

Хөдөлмөрийн үйл ажиллагаа:

1980-1996 онд Интернейшнл түүрс компанийн үүсгэн байгуулагч, захирал

1996-1999 онд Австралийн Алтан Ирэг дээрх Вотээмак зочид буудлын эзэн, "Скаймаак эйрлайн" компанийн үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн дарга

1999-2001 онд "Эйч Ай Эс кёрицү" үнэт цаасны компанийн Ерөнхийлөгч

2000 онд Токиогийн Хөрөнгийн биржийн толгой компани "Смаймак" үнэт цаасны ХХК-ийн Ерөнхийлөгч

2002 онд Токиогийн Хөрөнгийн биржийн толгой компани "Эйч Ай Эс" үнэт цаасны компанийн Ерөнхийлөгч

2003 онд Хаан банкны ТУЗ-ийн дарга

2004 оноос Токиогийн хөрөнгийн биржийн "Эйч Ай Эс" үнэт цаасны ХХК-ийн болон Осака хотын хөрөнгийн биржийн "Эйч Эс" үнэт цаасны ХХК-ийн Ерөнхийлөгчөөр ажиллаж байна.

Гадаад хэл эзэмшсэн байдал: Япон, Англи, Герман хэлтэй



Овог, нэр: Дашдаваагийн ХУЛАН

1968 онд Кубын нийслэл Гавана хотод төрсөн, эмэгтэй

Боловсрол:

1985-1990 онд Москвагийн Санхүүгийн Дээд сургуулийг Олон улсын эдийн засагч мэргэжлээр бакалавр

1992-1993 онд Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн удирдлагын магистр

1992-1993 онд Япон улсын сангийн яамнаас хагас жил тутам зохион байгуулдаг макро эдийн засгийн бодлого төлөвлөлтийн семинарт хамрагдсан.

Хөдөлмөрийн үйл ажиллагаа:

1990-1992 онд Монгол Улсын сангийн яаманд гадаад харилцааны хэлтэст эдийн засагч

1993-1997 онд “Говь” корпорацийн Токио дахь салбарт борлуулалтын менежер

1997-2000 онд Таван Богд Трейд компанийн тэргүүн дэд захирал

2000-2003 онд Худалдаа Хөгжлийн Банкны дэд захирал, “Кредит Монгол” зээлийн хорооны гишүүн

2003 оноос Таван Богд Группийн тэргүүн дэд ерөнхийлөгч, Хаан банкны ТҮЗ-ийн гишүүн

2007 оны 7 сараас Таванбогд группийн Тэргүүн дэд захирал

Гадаад хэл эзэмшсэн байдал: Орос, Англи, Испани, Япон хэлтэй



Овог, нэр: Дамбийжавын ХҮРЭЛБААТАР

1961 онд төрсөн, эрэгтэй

Боловсрол:

1979-1981 онд Худалдааны техникум, нягтлан бодогч

1984-1989 онд ОХУ-ын Иркутск хотын Санхүү Эдийн Засгийн Академи, санхүү эдийн засагч

1987-1989 онд ОХУ-ын Иркутск хотын Улс Төр Эдийн Засгийн Институт илтгэгч

Хөдөлмөрийн үйл ажиллагаа:

1981-1984 онд Монгол банкны Хяналт шалтгалтын газар Улсын байцаагч, хянагч

1989-1990 онд Монгол банкны Хяналт шалгалтын газар Улсын байцаагч, хянагч

1990-1991 онд Монгол банкны Гадаад харилцааны газар ахлах нягтлан бодогч

1991-2005 онд ХХБ-ны Харилцагчийн Үйлчилгээний Хэлтсийн захирал, Салбарын Удирдлагын Газрын захирал, Гүйцэтгэх захирлын орлогч

2005-2007 онд Монгол Шуудан банкны Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Үйл ажиллагааны газрын захирал

2007 оноос ХХБ-ны Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Үйл ажиллагааны газрын захирал

Гадаад хэл эзэмшсэн байдал: Англи, Орос хэлтэй



Овог, нэр: Зуунайн ШАГДАРСҮРЭН

1977 онд Улаанбаатар хотод төрсөн, эрэгтэй

Боловсрол:

1997-2001 онд	Токиогийн их сургуулийн Эрхзүйн баклавр
2001-2003 онд	Токиогийн их сургуулийн Эрхзүйн магистр
2005-2006 онд	АНУ, Мичиганы их сургууль, Эрхзүйн магистр

Хөдөлмөрийн үйл ажиллагаа:

Монгол банк, хуульч
Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк, хуульч

Монголын банкны холбоо, Гүйцэтгэх захирал

Гадаад хэл эзэмшсэн байдал: Англи хэлтэй

Хурлаас гарах шийдвэрийн төсөл

Төсөл

“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны ... дүгээр
Улаанбаатар

сарын ...-ны өдөр

Дугаар ...

ХОТ

*Компанийн 2015 оны үйл ажиллагааны
болон санхүүгийн тайлангийн тухай*

Говь хувьцаат компанийн 2015 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг хэлэлцээд тус компани өнгөрсөн онд техник технологийн шинэчлэлийг хийж, бүтээгдэхүүний нэр төрөл, загвар дизайныг олшруулан, гадаад, дотоод зах зээлээ тэлэх талаар тодорхой ажлуудыг төлөвлөн, амжилттай хэрэгжүүлж ажилласныг тэмдэглэж байна.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтыг үндэслэн “Говь” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь**:

Говь хувьцаат компанийн 2015 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны ... дүгээр
Улаанбаатар

сарын ...-ны өдөр

Дугаар ...

ХОТ

*Компанийн дүрэмд оруулах
өөрчлөлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 17.1, 62.1, “Компанийн тухай хуулийг дагаж мөрдөх журам”-ын дагуу 1.1-ийг үндэслэн “Говь” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

Говь хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс оруулсан компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны ... дүгээр
Улаанбаатар

сарын ...-ны өдөр

Дугаар ...

ХОТ

***Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг батлах тухай***

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалт, Компанийн дүрмийн 6.9.8 дахь заалтыг удирдлага болгон Тооллогын комиссын тооллогын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

Нэг. “Говь” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр:

1. Д. Хүрэлбаатар /УХ61111512/
2. Такеши Камбэ /TF7995260/
3. Т.Одмаа /ХА76010801/
4. Д.Гэрэлмаа /УХ65042803/
5. З.Шагдарсүрэн /ХВ77021376/ нарыг;

Хоёр. “Говь” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:

6. Ц. Баатарсайхан /ПБ66011274/
7. Д. Хулан /ХП68082200/
8. Хидео Савада /ТG5384200/
9. Д. Наранбаатар /ЦД82062574/ нарыг тус тус сонгосныг батламжилсугай.

ХУРЛЫН ДАРГА



MONGOLIAN CASHMERE “ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2016 оны 4 сарын 8-ны өдрийн 14 цагт Говь ХК-ийн дэргэдэх “Мираж” гэр ресторанд хуралдана.

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр

Эзэмшиж буй хувьцааны тоо төрөл *энгийн*

Дансны дугаар Регистрийн дугаар

Батлах асуудлууд: Зөвшөөрсөн Татгалзсан Түдгэлзсэн

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах /Саналыг энгийн аргаар тоолно/

Дүгнэлт: Өөрсдийн нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглан ажилласан

2. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг батлах /Саналыг энгийн аргаар тоолно/

Санал: Өөрчлөлтийг оруулая

3. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг батламжлах /Саналыг кумулятив аргаар тоолно/

Санал: ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгоё

- | | | | |
|----------------------------|--------------------------|--------------------------|--------------------------|
| 1. Дамбийжавын ХҮРЭЛБААТАР | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 2. Такеши КАМБЭ | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 3. Түнрэвийн ОДМАА | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 4. Дамбын ГЭРЭЛМАА | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 5. Зуунайн Шагдарсүрэн | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

Санал: ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгоё

- | | | | |
|---------------------------|--------------------------|--------------------------|--------------------------|
| 1. Цагаачийн БААТАРСАЙХАН | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 2. Дашдаваагийн ХУЛАН | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 3. Хидео САВАДА | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 4. Даваагийн НАРАНБААТАР | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

2016 оны ...-р сарын ...-ны өдөр

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг

“Говь” ХК-ийн ТУЗ-ийн 2016 оны
... дугаар сарын ... -ний өдрийн хурлын
... -р тогтоолын ... дүгээр хавсралт

САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Хувьцаа эзэмшигч саналын хуудсыг бөглөхдөө саналын хувилбарын зөвхөн нэгийг сонгож, (✓) тэмдэг тавина. Жишээ нь: зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (✓), татгалзсан бол татгалзсан гэсэн нүдэнд (✓) , түдгэлзсэн бол түдгэлзсэн гэсэн нүдэнд (✓) тэмдэг тавина.
2. Засварласан, балласан болон залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдно.
3. Хэрэв та саналаа өөр хүнээр төлөөлүүлэн өгөх бол таныг төлөөлөх хүний овог, нэр, хаягийг дор бичиж, гарын үсэг зуран, өөрийн иргэний үнэмлэх эсвэл итгэмжлэх бичгийг хувьцаа эзэмшиж буйг батлах бичиг баримтын хамт өгч ирүүлнэ.
4. Хэрэв та саналын хуудсаар саналаа өгөх бол хурлын материалтай танилцаад, санал авах хуудсанд саналаа тэмдэглэж, зуучлагч үнэт цаасны компанидаа эсвэл **Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, Говь ХК** хаягаар 2016 оны 04 дүгээр сарын 4-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Таныг төлөөлөх хүний:

Овог нэр

Таны: Эзэмшдэг хувьцааны тоо

Дансны дугаар

Регистрийн дугаар

Таны өөрийн гарын үсэг

Gobi Corporation
Industrial street, 3rd Khoroo, Khan-Uul District
Ulaanbaatar-17062 Mongolia, P.O.Box 36/434
Tel: (976-11) 341381, Fax: (976-11) 343081

www.gobi.mn